



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ ДӨРӨВДҮГЭЭР ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2010 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 04.

Өндөрхаан

**Аймгийн хөгжлийн цогц бодлого
батлах тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 дугаар зүйлийн а,е заалтуудыг үндэслэн Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлогын төслийн баримт бичгийг хэлэлцээд аймгийн ИТХ-ын ээлжит дөрөвдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1."Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого /2010-2021/-ыг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн жил жилийн төсөв, нийгэм эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны болон үндсэн чиглэлд тусгах замаар хэрэгжилтийг зохион байгуулж, явц үр дүнг аймгийн ИТХ-д жил тутам танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ч.Эрдэнэбаатар/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ЛХАГВАСҮРЭН

**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР**

ХЭНТИЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО

(2010 – 2021 он)

Өндөрхаан, 2009 он.

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газартай Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шинжлэх ухааны Академийн харъяа Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн байгуулсан 2008 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн №ХЭ/ҮХХ-08 тоот гэрээний дагуу “Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)”-ыг Төслийн удирдагч, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн дэд захирал, доктор, профессор Д.Бямбаа, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн ахлах судлаач Л.Нямцэрэн, зөвлөх судлаач А.Зоригсайхан, Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн багш, доктор П.Гантөмөр, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр Б.Сайнбилэг, Б.Цогтбаатар, Р.Онгонцэцэг, Г.Хажидмаа нарын судлаачдын баг боловсруулан, Хэнтий аймгаас Улсын Их Хуралд сонгогдсон УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Н.Ганбямба, Д.Арвин нарын саналыг тусган хийж гүйцэтгэв.

Энэхүү цогц бодлогыг Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн 2009 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн гарсан санал, зөвлөмжийг тусгасны зэрэгцээ Хэнтий аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахын өмнө тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа агентлагуудын түвшинд хэлэлцүүлэн ирүүлсэн санал, Хэнтий аймгийн ЗДТГ, ИТХ-ын удирдлагаас ирүүлсэн санал, мөн аймгийн ИТХ-ын Байнгын хороодын гишүүд, тухайн салбартай холбоотой хэлтэс, агентлагуудын удирдлага, мэргэжилтнүүдийн оролцсон салбар бүрийн хэлэлцүүлэг, тодруулгуудыг тусгаасан болно. Мөн Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийн саналыг тусгав. Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)-ын тооцооны үндэслэлийг хавсралт болгон оруулав.

ГАРЧИГ

ОРШИЛ	5
НЭГ. ХЭНТИЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД	6
1.1. Хэнтий аймгийн хөгжлийн өнөөгийн байдал.....	6
1.2. Хэнтий аймгийн хөгжлийн давуу болон сул талууд.....	10
	11
ХОЁР. ХЭНТИЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД	
2.1. Хэнтий аймгийн хөгжлийн алсын хараа.....	11
2.2. Хэнтий аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд.....	11
ГУРАВ. ХЭНТИЙ АЙМГИЙН ХҮНИЙ ХИЙГЭЭД НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	12
3.1. Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого.....	12
3.2. Хүн ам зүйн бодлого.....	15
3.3. Боловсрол, соёлын хөгжлийн бодлого.....	17
3.4. Эрүүл мэндийн хөгжлийн бодлого.....	22
ДӨРӨВ. ХЭНТИЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО	24
4.1. Макро эдийн засгийн бодлого.....	24
4.2. Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого.....	26
4.2.1. Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого.....	26
4.2.2. Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого.....	31
4.2.3. Аялал жуулчлалын хөгжлийн бодлого.....	36
4.3. Дэд бүтцийн хөгжлийн бодлого.....	37
4.3.1. Зам, тээврийн хөгжлийн бодлого.....	38
4.3.2. Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого.....	39
4.3.3. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлого.....	39
4.4. Хот байгуулалт, барилгын салбарыг хөгжүүлэх бодлого.....	41
	44
ТАВ. ХЭНТИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО	49
ЗУРГАА. ХҮРЭХ ГОЛ ҮР ДҮН, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ ..	
6.1. Цогц бодлого хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн.....	49
6.2. Цогц бодлогын хэрэгжилтийг хангах механизм.....	50
	52
Хавсралт	

ОРШИЛ

1. Монгол Улсын Ерөнхийлөгч санаачилж, манай орны эрдэмтэн судлаачид, улс төрийн намууд, иргэдийн өргөн оролцоотойгоор боловсруулж, УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2007-2021 он)”-д тулгуурлан “Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021 он)”-ыг боловсруулав.

2. “Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010- 2021он)”-ын үндэслэл нь “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)”, “Монгол Улсын Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөр (2015 он хүртэл)” болон Монгол Улсын хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдийн гол үзэл санаа болсон юм.

3. “Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021он)”-д аймгийн хэмжээний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн үзэл санаа, хэрэгжилтийн явц, үр дүн, залгамж чанар бүрэн тусгалаа олсон болно.

4. Хэнтий аймгийн урт хугацааны хөгжлийн стратегийн зорилтууд, хүрэх үр дүнг 2010-2015 он, 2016-2021 он гэсэн хоёр үндсэн үе шатаар тусгав.

НЭГ. ХЭНТИЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХӨГЖЛИЙН ДАВУУ БОЛОН СУЛ ТАЛУУД

1.1. Хэнтий аймгийн хөгжлийн өнөөгийн байдал

Хэнтий аймагт 2008 оны байдлаар 71.0 мянган суурин хүн ам оршин сууж байгаа нь улсын нийт хүн амын 2.6 хувийг эзэлж байна. Аймгийн хэмжээнд нийт 19.5 мянган өрх байгаагаас хөдөөд 12.2 мянган өрх амьдарч байна. Тус аймагт 2008 оны байдлаар 1000 хүнд ногдох төрөлт 25.1 нас баралт 6.8, цэвэр өсөлт 18.2, дундаж наслалт 67.2, төрсөн хүүхэд 1785 байна.

Аймгийн хэмжээнд эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 2008 оны байдлаар 27,7 мянган хүн, ажиллагчдын тоо 26,5 мянга, бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1067, үүнээс эмэгтэй 586, дээд боловсролтой 182, тусгай дунд боловсролтой 44, мэргэжлийн анхан шатны боловсролтой 101, мэргэжилгүй 740 хүн байна.

Тус аймагт ажилгүйдлийн түвшин 2008 оны байдлаар 3,9 байгаа нь Зүүн бүсийн дунджаас 0,3 хувиар их байна.

Ажилгүйдэл, ядуурлыг багасгахад аймгийн хөгжлийн давуу тал, нөөц боломжийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэл, үйлчилгээг бүх талаар дэмжин ажлын байрыг олноор бий болгох, эдийн засгийн өсөлт, тэргүүлэх салбаруудын хөгжил, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдсан хөдөлмөр эрхлэлтийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Тус аймагт 2008-2009 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 27 сургуульд 15.0 мянган сурагч суралцаж байна. ЕБС-д 734 багш ажиллаж байгаа бөгөөд нэг багшид 27,4 сурагч ногдож байна. Суурь боловсролын хамран сургалтын бохир жин 96,6, бага боловсролынх 97,0, дунд боловсролынх 96,1 байна.

Тус аймгийн 28 цэцэрлэгт 147 багш ажиллаж байгаа бөгөөд цэцэрлэгт нийт 2.9 мянган хүүхэд, яслид 66 хүүхэд хүмүүжиж байна. Боловсролын салбарын шинэчлэлийг гүнзгийрүүлж, бүх шатны сургуулиудын сургалтын чанарыг сайжруулах шаардлагатай байна.

Хэнтий аймагт 2008 оны байдлаар 404 суудал бүхий 23 нийтийн номын сан ажиллаж байгаа бөгөөд уншигчдын тоо 7003 хүн байна.

Хэнтий аймагт 4600 суудал бүхий 22 соёлын төв, 2 сүм хийд ажиллаж байна.

Цаашид соёл урлагийн байгууллагуудын урын санг баяжуулах, музей, соёлын төв, номын сүлжээг төрөлжүүлэх, иргэдэд үзүүлэх соёл урлагийн үйлчилгээний чанарыг шаардлагын хэмжээнд хүргэх, соёлын өв тээгчдийг сурталчлах, өвлөн авах, ЕБС-ийг түшиглэн ардын уламжлалт урлагийн сургалтуудыг нээн хичээллүүлэх, түүх соёлын дурсгалт зүйлсийг хадгалах хамгаалах ажлыг цогц байдлаар шийдвэрлэх шаардлагатай байна.

Хэнтий аймагт 2008 оны байдлаар эрүүл мэндийн салбарт 150 их эмч, 7 эм зүйч ажиллаж байгаа бөгөөд нэг эмчид 474, нэг сувилагчид 328 хүн ногдож байна. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн өвчтөний тоо 2008 оны байдлаар 17,0 мянган хүн байна. Эрүүл мэндийн салбарын боловсон хүчний хангалт, мэргэжлийн ур чадварын түвшин харилцан адилгүй, эмнэлгүүдийн төсөв материаллаг баазын хангамж, хүрэлцээ хангалтгүйгээс эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмж шаардлагын түвшинд хүрээгүй байна.

2008 оны байдлаар Хэнтий аймаг 23 спорт заалтай, спортоор хичээллэгчид 6918, биеийн тамираар хичээллэгчид 12849 хүн байна. Спортын цол зэрэгтэй тамирчид 3251, цол зэрэгтэй шүүгчид 201, улсын цолтой бөх 16, аймгийн цолтой бөх 286, сумын цолтой бөх 299, цолтой сур харваачид 36, цолтой уяачид 14 байна.

Хэнтий аймаг улсын ДНБ-ний 1.3 хувийг, Зүүн бүсийн 24.0 хувийг үйлдвэрлэж байна. Тус аймаг 2008 онд 80235,5 сая төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэснээс хөдөө аж ахуйн салбар 71,3 хувийг, аж үйлдвэр барилгын салбар 2,5 хувийг, үйлчилгээний салбар 26,2 хувийг тус тус үйлдвэрлэжээ. Бусад аймагтай харьцуулахад эдийн засгийн салбарын бүтэц хоцрогдонгуй хэвээр байгаа бөгөөд бэлчээрийн мал аж ахуйд суурилсан ХАА голлох үүрэгтэй байна. Аймгийн эдийн засагт нааштай өөрчлөлтүүд гарч байгаа хэдий ч урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай томоохон асуудлууд цөөнгүй байна.

Хэнтий аймаг 2008 оны байдлаар оны үнээр 80235,5 сая төгрөгийн ДНБ үйлдвэрлэсэн бөгөөд үүнийг 2005 оны үнээр авч үзвэл 52568,3 сая төгрөг болж байна. 2008 оныг 2007 онтой харьцуулбал нэрлэсэн ДНБ 35,9 хувиар өсч, бодит ДНБ 18,5 хувиар буурчээ. 2005 оны үнээр тооцсон үйлдвэрлэлийн хэмжээг салбаруудаар авч үзвэл, ХАА-н салбарт 43385,5 сая төгрөг, уул уурхай, олборлох үйлдвэрт 304,1 сая төгрөг, боловсруулах салбарт 95,0 сая төгрөг, цахилгаан, дулааны салбарт 186,6 сая төгрөг, барилгын салбарт 404,2

сая төгрөг, үйлчилгээний салбарт 8229,4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэжээ.

Зүүн бүсийн бусад аймгуудтай харьцуулбал, Хэнтий аймгийн эдийн засагт хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувийн жин харьцангуй өндөр буюу аймгийн ДНБ-ий 71.3 хувийг эзлэж байна. Ойрын жилүүдэд ашигт малтмал олборлох, малын гаралтай түүхий эдийг боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хүнсний ногоо, сүү, цагаан идээ боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар аж үйлдвэрийн салбарт өндөр өсөлтийг бий болгох шаардлагатай.

Хэнтий аймагт регистрийн санд бүртгэлтэй 686 аж ахуйн нэгж байгууллага байгаагаас одоо үйл ажиллагаа явуулж байгаа 568 аж ахуйн нэгж байгууллага байна.

2008 онд Хэнтий аймагт 2136.9 мянган мал тоологдсоноос адуу 143,3 мянга, хонь 1008,2 мянга, тэмээ 4.0 мянга, үхэр 158,6 мянга, ямаа 822,8 мянга байна. Малчин өрхийн тоо 7445, малчдын тоо 14463 байна.

Тус аймаг 2008 онд 3,4 мян.га газар тариалалт хийснээс 2620 га-д үр тариа, 361,5 га –д төмс, 164,5 га-д хүнсний ногоо тариалж, 2018,0 тн үр тариа 2905,8 тн хүнсний ногоо, 1705,3 тн төмс хураан авчээ.

Хэнтий аймагт ашигт малтмалын 62 орд, 259 илрэл, 360 эрдэсжсэн цэг илэрснээс чулуун нүүрсний 1, хүрэн нүүрсний 10, шатдаг занарын 3, нефтийн 3, битумын 3, төмрийн хүдрийн 20, кобальт никелийн 5, хар тугалганы 9, цайр, зэсийн 25, цайрын 11, цагаан тугалганы 51, вольфрамын 40, молибдений 20, алт, мөнгөний 92, ураны 6, радигийн 1, газрын ховор элементийн 3 орд, илрэл тус тус бүртгэгдээд байна.

Хэнтий аймагт 69 аж ахуйн нэгж ашиглалтын лицензээр 14784 га талбайд алт, жонш, цагаан тугалга, нүүрс зэрэг ашигт малтмалын олборлолт явуулахаар зөвшөөрөл авчээ. Өнөөдрийн байдлаар “Бор-Өндөрийн” УБҮ Бор-Өндөрийн болон Адагийн жоншны ордод олборлолт явуулж жилдээ 150.0 мян.тн жонш, “Бэрх-Уул” ХК нь Чандганы нүүрсний уурхайд 35 мян.тн, Бэрхийн болон Дэлгэрхааны жоншны гүний ордод олборлолт явуулж 6.0 мян.тн жонш, “Идэр гоулд” ХХК Хавтгайн ордод 10.0 мян.тн нүүрсний олборлолт, “Бэрх-Уул” ХК Тохой булгийн ордод 10 кг алт, “Баян-Эрдэс” ХХК Салхитын ордод 5 кг алт, “Эрэлчин” ХХК Хадагтайн ордод 5-10 кг алт, “Морьтхангай” ХХК Баянцогтод вольфромын, Баянхутаг сумын сондуультын 12 сая м³ шаврын ордоос тоосгоны шавар болон Өндөрхаан хотын ойр орших дулааны энгэрийн элсний

карьераас элс, Хэрлэн голын эргийн хэсгээс хайрганы олборлолт явуулж байгаа бөгөөд “Баялаг Чандган” ХХК Чандганы ордод нүүрс, “Баянмод-Уул” ХХК Баянмодны ордод холимог металлын олборлолт явуулахаар болсон бол бусад аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа эхлээгүй байна.

Өнөөдөр ашиглаагүй боловч цаашид ирээдүйтэй зарим ордуудыг дурьдвал гянтболдын нөөцөөрөө Монголд тэргүүлэх Өндөрцагааны орд /175 мян.тн/, Мөрөн сумын нутагт орших нүүрсний орд /2 тэрбум тн/, Өмнөдэлгэр сумын нутагт орших Мөнгөн-Өндөрийн мөнгө-холимог металлын орд /31.3 сая.тн/, Сондуультын тоосгоны шаврын орд /15 сая.м³/ зэрэг болно.

Хэнтий аймаг нь Зүүн бүсийн бусад аймгуудыг бодвол дэд бүтцийн хөгжлөөр харьцангуй сайн байна. Сүүлийн 3 жилд бүх төрлийн эх үүсвэрээс нийт 49,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд дэд бүтцийн салбарт 70 хувийг нь зарцуулжээ.

Зүүн бүсийн аймгууд нь бусад аймаг, хотуудтай голчлон автозамаар холбогддог бөгөөд зүүн бүсийг төвийн бүстэй холбох ажил “Мянганы зам” төслийн хүрээнд хэрэгжиж, Багануур - Өндөрхаан чиглэлийн хатуу хучилттай замыг барьж дуусган, Өндөрхаан - Сүмбэр чиглэлийн 50 км хатуу хучилттай замыг энэ жил ашиглалтад оруулах ба үргэлжлүүлэн 50 км замыг барьж Чойбалсан, Баруун-Урт хотуудыг холбох хэвтээ тэнхлэгийн замын ажил үргэлжлэн явагдаж байна.

Зүүн бүсийн хөгжилд эрчим хүчний найдвартай хангамж чухал бөгөөд Монгол улсын “Эрчим хүчний нэгдсэн сүлжээ” хөтөлбөрт тусгагдсаны дагуу Өндөрхаан – Баруун-Уртын 110 квт, Өндөрхаан - Чойбалсангийн 220 квт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг барьснаар зүүн бүсийн аймгуудыг төвийн бүстэй эрчим хүчний нэгдсэн сүлжээгээр холбож энэ нь ирээдүйд тус бүсэд уул уурхайн том үйлдвэрүүд, худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд ихээхэн түлхэц болох юм.

Хэнтий аймагт орчин үеийн шаардлагад нийцсэн хот байгуулалтын цэгцтэй бодлого үгүйлэгдэж байна. Одоо мөрдөж байгаа аймаг, сумын төвийн ерөнхий төлөвлөгөөнүүдийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай.

Хэнтий аймгийн хөгжлийн бас нэг тулгуур нь түүх, соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газруудад түшиглэн аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх боломжтой.

Хэнтий аймгийн цаг уурын олон жилийн дундаж үзүүлэлтийг авч үзвэл, тунадас 259,4 мм, агаарын температур 1 дүгээр сард $-23,4$ хэм C^0 , 7 дугаар сард $18,7$ хэм C^0 , 2008 оны байдлаар гарсан ойн түймэр 6, ойгоос бэлтгэсэн мод $18,7$ мянган m^3 , гол горхи 255, булаг шанд 611, рашаан 18, нуур тойром 288 байна. Агаар дахь бохирдуулагч бодисын жилийн дундаж агууламж $0,004$ $мкг/м^3$ байна.

Байгаль хамгааллын шийдвэрлэвэл зохих асуудлууд ч цөөнгүй хуримтлагджээ. Малын тоо толгой сүүлийн жилүүдэд өсөж, нийт нутгийн хэмжээгээр бэлчээрийн даац хүрэлцэхгүй байдал ажиглагдаж байна. Худаг, ус тойрсон бага хэмжээний газар олон тооны мал төвлөрч бэлчээрийн талхагдлыг ихэсгэж байна. Мөн байгалийн баялгийг зүй бусаар ашиглах явдал ихэсч байна. Нэн ялангуяа дэлхийд ховордсон улаан номонд орсон амьтныг агнаж устгах явдал гарсаар байна. Иймд аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах, зохистой ашиглах асуудал нэн чухал байна.

Зуд, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, мөндөр, хүйтэн бороо орох, үер, ган, хүн, мал, ургамал, амьтны гоц халдварт өвчин, ой хээрийн түймэр зэрэг байгалийн гэнэтийн үзэгдэл, гамшиг үе үе тохиолдож мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл болон эдийн засаг, байгаль орчинд багагүй хохирол учруулсаар байна.

Байгалийн гамшгийг судлах, урьдчилан сэргийлэх, нэгэнт тохиолдсон гамшигтай тэмцэх, учирсан хохирлыг нь багасгах чиглэлээр олон улсын байгууллагуудаас дэмжлэг туслалцаа үзүүлж, удирдлага зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээ авдаг боловч гамшгийн хохирлын хэмжээ тууштай буурахгүй байна.

1.2. Хэнтий аймгийн хөгжлийн давуу болон сул талууд

Хэнтий аймгийг 2010-2021 он хүртэл хөгжүүлэх цогц бодлогод хөгжлийн дор дурьдсан давуу болон сул талуудыг тооцон үзэв. Үүнд:

Хөгжлийн давуу талууд:

- Хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин өндөр;
- Боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлж экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд өрсөлдөхөд ашиглаж болох МАА-н түүхий эдийн арвин нөөцтэй;
- Эрдэс баялгийн нөөцөө ашиглаж уул уурхай, барилгын материалын томоохон үйлдвэрүүдийг байгуулан хөгжүүлэх боломжтой;

- Дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн;
- Байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломжтой.

Хөгжлийн сул талууд:

- Хүн амын тоо цөөн, өсөлт удаан, тархай бутархай байршилтай;
- Ажилгүйдэл ядуурлын түвшин өндөр;
- Боловсрол, эрүүл мэндийн салбарын хөгжлийн түвшин доогуур, энэ талын тулгамдсан олон асуудлууд хуримтлагдсан;
- Эдийн засгийн салбарын бүтэц ихээхэн хоцрогдсон, эдийн засагт бэлчээрийн МАА-д суурилсан хөдөө аж ахуйн салбар голлох үүрэгтэй;
- МАА, газар тариалангийн үйлдвэрлэл байгаль, цаг агаарын байдлаас хэт хамааралтай.

ХОЁР. ХЭНТИЙ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН АЛСЫН ХАРАА, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

2.1. Хэнтий аймгийн хөгжлийн алсын хараа

Хэнтий аймгийн хөгжлийн 2021 он хүртэлх **алсын хараа** нь хүний хөгжилд тулгуурлан эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж хүн амын амьдралын түвшинг тууштай дээшлүүлэн, Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж, Монгол Улсын өөрөө өөрийгөө тэтгэдэг, оновчтой бүтэцтэй, мэдлэгт суурилсан эдийн засагтай, Зүүн бүсийн цэцэглэн хөгжиж буй аймаг болоход оршино.

2.2. Хэнтий аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд

Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлогыг дараах зургаан тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ.

1. Мянганы хөгжлийн зорилтуудыг тус аймагт хэрэгжүүлж, хүнийг бүх талаар хөгжүүлнэ.
2. Дэлхийн болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадвартай, хувийн хэвшилд тулгуурласан экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг эрчимтэй хөгжүүлж, аймгийн эдийн засгийг олон талтай, мэдлэгт суурилсан болгоно.
3. Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг эрчимтэй хөгжүүлж, хөгжлийн таатай орчин бүрдүүлнэ.
4. Аймгийн төв, бичил бүс, сумдын төвүүдийг хөгжүүлж хот, хөдөөгийн хөгжлийн түвшний ялгааг багасгана.

5. Аялал жуулчлалын салбарыг аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгон хөгжүүлнэ.
6. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон чадавхийг бий болгон экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

ГУРАВ. ХЭНТИЙ АЙМГИЙН ХҮНИЙ ХИЙГЭЭД НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хэнтий аймгийн хөгжлийн 1 дэх тэргүүлэх чиглэлийн хүрээнд аймагт ядуурал, ажилгүйдлийг тууштай бууруулж иргэн бүрийн амьдралын чанарыг тасралтгүй дээшлүүлнэ. Гэр бүлийг хөгжүүлж, хүн ам зүйн оновчтой бодлогыг хэрэгжүүлнэ. Хүн амын боловсрол, соёл, эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг эрс сайжруулна. 2015 он гэхэд Мянганы хөгжлийн зорилтуудыг бүрэн хэрэгжүүлнэ.

3.1. Ядуурал, ажилгүйдлийг бууруулах бодлого

Үндэслэл: Хэнтий аймгийн эдийн засгийн идэвхитэй хүн амын тоо 27,5 мянга, ажиллагчдын тоо 26,5 мянга, бүртгэлтэй ажилгүйдлийн тоо 1067, ажилгүйдлийн түвшин 3,9 хувьтай байна.

Зүүн бүсийн хувьд амьжиргааны доод түвшинг нэг хүнд сард ногдохоор авч үзвэл 86300 төгрөг, ядуурлын үндсэн үзүүлэлтүүд, тухайлбал, ядуурлын хамралтын хүрээ 46,7 хувь, ядуурлын гүнзгийрэлт 14,9 хувь, ядуурлын мэдрэмж 6,6 хувьтай байна.

Хэнтий аймагт 2008 оны байдлаар мэргэжлийн сургалтанд 660 хүн хамрагдаж, 450 гаруй хүн ажлын байртай болж, нийтийг хамарсан ажилд 900 иргэн хамрагдан 65.2 сая төгрөгийн зардал гарсан байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 1700 хүн хамрагдан 902,1 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмжид 3500 хүн хамрагдан 565,7 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 1000 иргэн хамрагдаж 86,1 сая төгрөг тус тус зарцуулжээ.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн хэмжээнд ядуурлыг 2.0 дахин бууруулна.

- Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлоготой нягт уялдуулан “Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах дунд хугацааны хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлэх;

- Эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалтын арга хэмжээтэй нягт уялдуулан ажлын байрыг тууштай нэмэгдүүлж, ажилгүйдлийн түвшинг 2.0 хувиас дээшгүй байлгах;
- Ажлын байр шинээр бий болгосон аж ахуйн нэгж, байгууллагад эдийн засгийн урамшуулал олгох;
- Ажилгүй, ядуу, нэн ядуу иргэдэд мэргэжил, ажлын дадлага туршлага эзэмшүүлэх, хөгжлийн зээл, тусламжид хамруулах зэргээр дэмжлэг үзүүлэх;
- Ядуу, бага орлоготой малчин өрхийг уламжлалт мал маллагааны арга барилд сургах, малжуулах;
- Ядуу өрхөд аж ахуй эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах, ялангуяа цөлжилттэй тэмцэх, ойн зурвас байгуулах, хөрс, бэлчээрийг хамгаалах ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг өргөнөөр татан оролцуулах;
- Ядуурлыг бууруулах зорилгоор хэрэгжүүлж байгаа олон улсын төсөл хөтөлбөрүүдийн үйл ажиллагааг орон нутагт идэвхжүүлж, уялдаа холбоог сайжруулах;
- Хөдөлмөр эрхлэлтийн сан болон бусад хөтөлбөр, төслүүдийн хүрээнд хугацааны хувьд байнгын, үнэлгээний хувьд цалин өндөртэй ажлын байрыг бий болгох;
- Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц, аялал жуучлалын салбарт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
- Хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэжлийн сургалтыг өргөтгөх хөтөлбөрийг хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.
- Мэргэжлийн болон ур чадварын сургалтанд 600-аас доошгүй иргэнийг хамруулах;
- Мэргэжил харгалзахгүй ажилд иргэдийг хамруулан цалин хөлс олгох.

Стратегийн зорилт 2. Нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж, чанарыг эрс сайжруулж, эмзэг бүлгийн иргэдийн нийгмийн хамгааллын тогтолцоог боловсронгуй болгоно.

- Аймгийн төв, бичил бүс, сумын төвүүдийн түвшинд нийгмийн бүх төрлийн үйлчилгээг эрс сайжруулах;
- Нийгмийн даатгалд хамрагдах хүрээг нэмэгдүүлж, тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд аймгийн хүн амыг бүрэн хамруулах;

- “Тогтвортой амьжиргааг дэмжих” төслийн хүрээнд ядуу, эмзэг бүлгийн иргэдэд туслах зорилгоор банк, санхүүгийн үйлчилгээг сайжруулах;
- Бүтэн өнчин, тэнэмэл, нэн ядуу өрхийн хүүхдүүдийг байрлуулж хооллон, сургалт явуулах халамжийн төвүүдийг байгуулан ажиллуулах;
- Ядуу иргэд, орон гэргүй хүмүүс гэр, хашаа, орон сууц худалдан авах, барих, орон байраа өргөтгөх, засварлах зориулалт бүхий орон сууцны зээлийн үйлчилгээг сайжруулах;
- Нийгмийн эмзэг, ядуу, нэн ядуу иргэдийн бэлэнчлэх сэтгэлгээ, хандлагыг өөрчлөн амьжиргаагаа дээшлүүлэх чадавхитай болгох;
- Хөдөлмөр эрхлээгүй хүмүүс, ялангуяа нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг дэд бүтэц, аймаг, нийтийн аж ахуйн болон нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжийн тохижилт, үйлчилгээний ажлын хэсгийг гэрээгээр гүйцэтгүүлэх тогтолцоонд шилжих;
- Ахмад настны амралт сувилалын газар, чийрэгжүүлэлтийн танхим нээн ажиллуулах, тэдэнд үзүүлж байгаа тусламж, хөнгөлөлтийг боловсронгуй болгох;
- Байнгын ажиллагаатай хүүхдийн хөгжлийн төвийг байгуулж ажиллуулах;
- Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг зөвөлгөө өгөх төвийг байгуулж ажиллуулах.
- Нийгмийн халамжийн тэтгэвэр олгох үйлчилгээг 1700-аас доошгүй өрх иргэдэд үзүүлэх;
- Нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 2000-гаас доошгүй иргэдэд үзүүлэх.

Хоёрдугаар үе шат (2016-2021он):

Стратегийн зорилт 1. Ядуурлыг бууруулахад бүхий л хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тэгш оролцоог ханган ядуурлыг эрс бууруулна.

- Ажилгүйдлийн түвшинг 2,8 хувьд хүргэх;
- Ядуурлыг бууруулах, амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрийн талаар аймгийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх;
- Амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, хоршоо, фермерийн аж ахуй байгуулах, байгаль хамгаалах, нөхөн сэргээх зэрэг чиглэлээр бүх талаар дэмжих.
- Нийтийг хамарсан ажилд орлогогүй, ажилгүй иргэдийг өргөн хүрээтэй хамруулах.

Стратегийн зорилт 2. Нэн ядуу иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг боловсронгуй болгоно.

- Бүтэн өнчин, тэнэмэл болон нэн ядуу өрхийн хүүхдийг байрлуулж хооллон, сургалт явуулах халамж үйлчилгээний төвүүдийг шаардлагатай газарт шинээр байгуулах;
- “Нийгмийн халамжийн сан”-гийн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх;
- Тахир дутуу иргэдэд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээний хүрээ, хүртээмжийг тэдний амьдралын чанар, онцлогийг харгалзан нэмэгдүүлэх;
- Ахмад настанд үзүүлдэг тусламж, хөнгөлөлтийг сайжруулж, өрхийн тэтгэмжийн төрлийг шинээр бий болгох.

3.2. Хүн ам зүйн бодлого

Үндэслэл: 2008 оны байдлаар Хэнтий аймгийн хүний хөгжлийн индекс 0.699, хүн амын дундаж наслалтын индекс 0703, хүн амын боловсролын түвшний нэгдсэн индекс 0446, нэг хүнд ногдох ДНБ-ний (валютын худалдан авах чадварын паритет ам.доллар) индекс 0.476 байна.

2008 оны байдлаар Хэнтий аймгийн суурин хүн ам 71 мянга, 16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш насны хүүхэдтэй өрхийн тоо 978, өрх толгойлсон эмэгтэйчүүдтэй өрхийн тоо 2983, төрөлт 1785, нас баралт 487, цэвэр өсөлт 1298, гэрлэлт 727, цуцлалт 21, үрчлэгдсэн хүүхдийн тоо 119 байна. Аймгийн хувьд 1000 хүнд ногдох төрөлт 25.1 нас баралт 6.8, цэвэр өсөлт 18.2, гэрлэлт 17,0, цуцлалт 0,5, үрчлэлт 1,7 байна. Хүн амын дундаж наслалт 67.4 байна.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Хүн амын жилийн дундаж өсөлтийг тууштай нэмэгдүүлж 1.7 хувьд хүргэнэ.

- “Гэр бүл, хүүхдийн цогц хөгжил” аймгийн дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Аймаг, сумдын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд хүн амын хүчин зүйлсийг оновчтой тусган хэрэгжүүлэх;
- Залуу гэр бүл, шинээр төрсөн хүүхдийг дэмжих сан байгуулж ажиллуулах;
- Аймгийн төв, сумдын эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх замаар хүн ам төрж, өссөн нутагтаа тогтвор сууршилтай амьдрах, ажиллах нөхцлийг бүрдүүлэх;

- Хүн амын эмзэг бүлгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Өрх нэг бүрээр угийн бичиг хөтлүүлж занших;
- Хүн амын дундаж наслалтыг 68-д хүргэх;
- Бичиг үсэг үл мэдэх явдал, сургууль завсардалтыг арилгах.

Стратегийн зорилт 2. Хүнийг бүх талаар хөгжүүлэн, бүсийн хэмжээнд хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлтийг 0.700-аас бууруулахгүй байна.

- Бүс, аймаг, сумдын түвшинд бүх шатны сургалтын материаллаг баазыг бэхжүүлэн сургалтын чанарыг сайжруулах;
- Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг тууштай сайжруулах;
- Аймгийн эдийн засгийн өсөлтийг хурдасгаж, салбарын бүтцийг шинэчлэх бодлоготой уялдуулан хүн амын орлогыг тасралтгүй нэмэгдүүлэх.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Хүн амын жилийн дундаж өсөлтийг 2.0 хувьд хүргэнэ.

- Аймгийн эдийн засгийн өсөлтийг түргэсгэн ажлын байрны хангамжийг сайжруулах замаар гадагш чиглэсэн шилжих хөдөлгөөнийг бууруулах;
- Төрөлтийг дэмжих зорилгоор өрхийн орлогод ногдох албан татварт хөнгөлөлт үзүүлэх, өрхийн хүүхдийн тоо, насны ялгааг харгалзан тэтгэлэг олгох зэрэг арга хэмжээний хамрах хүрээг өргөтгөх;
- Хүн амын дундаж наслалтыг 72-д хүргэх.

Стратегийн зорилт 2. Хүнийг хөгжүүлэх боломжийг бүрэн дүүрэн ашиглах замаар аймгийн хэмжээнд хүний хөгжлийн индексийн дундаж үзүүлэлтийг 0.720-аас бууруулахгүй байна.

- Мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавьж, бүс, аймаг, сумдын түвшинд хүн амын орлогыг нэмэгдүүлэх, боловсролын түвшинг дээшлүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах арга хэмжээг тууштай үргэлжлүүлэх;
- Албан ба албан бус боловсролын тогтолцоог боловсронгуй болгож, бүх шатны боловсролын хүртээмжийг сайжруулах;
- Нийт малчдыг зайны сургалтад хамруулах оновчтой арга, хэлбэрийг сонгон нэвтрүүлэх;
- Үйлдвэрлэлийн салбарын бүтэц, өсөлттэй уялдуулж мэргэжилтэй ажилтан бэлтгэх тогтолцоог оновчтой болгох.

3.3. Боловсрол, соёлын хөгжлийн бодлого

Үндэслэл: Хэнтий аймагт 2008-2009 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 27 сургуульд 15.0 мянган сурагч суралцаж, 734 багш ажиллаж байгаа бөгөөд нэг багшид 27,4 сурагч ногдож байна. Тус аймгийн суурь боловсролын хамран сургалтын бохир жин 96,6, бага боловсролынх 97,0, дунд боловсролынх 96,1 байна. Тус аймгийн 28 цэцэрлэгт 147 багш ажиллаж, цэцэрлэгт нийт 2.9 мянган хүүхэд, яслид 66 хүүхэд хүмүүжиж байна. ЕБС 12 жилийн тогтолцоонд шилжиж, 6 настай хүүхдийн хамран сургалт 96.7%-тай болжээ. Энэ хичээлийн жилд давхардсан тоогоор 960 багш орон нутгийн болон үндэсний хэмжээний сургалтад хамрагдсан бөгөөд аймгийн хэмжээнд шилэн кабелиар 5 сургууль, сансарын антенаар 3 сургууль интернэтийн сүлжээнд холбогдоод байна. Хүн амын бичиг үсгийн боловсролын түвшин тогтоох шалгуур байхгүй, бичиг үсгийн тайлагдалтын түвшин 97.7 хувьтай байна. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын чанарын түвшинг тогтоох ажил хийгдээгүй.

Тус аймагт 404 суудал бүхий 23 нийтийн номын сан ажиллаж, уншигчдын тоо 7003-д хүрсэн, номын сангийн цогц программ ЛАЙБ4-ийг суурилуулж дотоод сүлжээнд 4 компьютер холбогдсон. Мөн 4600 суудал бүхий 22 соёлын төв, 2 сүм хийд ажиллаж байна. Ардын дуу бүжгийн “Хан Хэнтий чуулга” нь 350 хүний суудлын багтаамжтай, мэргэжлийн боловсон хүчний хангалт 14,2 хувьтай байна. Тус чуулга нь 2008 онд 3641 хүнд үйлчилж, 490500 төгрөгийн орлого оруулжээ.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлнэ.

- Ерөнхий боловсролын сургуулиудын байршил, хэв шинжийг орон нутгийн засаг захиргааны нэгжийн өөрчлөлттэй уялдуулан оновчтой тогтоох;
- Зүүн бүсийн МСҮТөвийн барилгыг шинээр барих, мэргэжилгүй ажилгүй залуусыг суралцуулах;
- Сум бүрт сургуулийн өмнөх боловсролыг гэрийн нөхцөлд ойртуулах арга хэмжээ авч, хүүхдийн цэцэрлэгийн хамран сургалтыг нэмэгдүүлэх;
- ЕБС-д суралцагчдын хүйсийн тэгш бус байдлыг арилгах;
- Бүх нийтийн монгол хэл, бичгийн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, бүх шатны сургуульд эх хэлээ төгс эзэмших нөхцлийг бүрдүүлэх;
- Англи хэлийг бүх нийтийн голлох гадаад хэл болгох;

- Бүрэн ба бүрэн бус дунд боловсрол эзэмшигчдэд мэргэжлийн боловсролыг давхар эзэмшүүлэх арга хэмжээ авах;
- Төрийн бус өмчийн сургуулийг аймаг, сумдын төвд байгуулан ажиллуулахад бүх талын дэмжлэг үзүүлэх;
- Малчдын хүүхдийг сургуульд бэлтгэх оновчтой хэлбэр болох явуулын багштай нүүдлийн болон гэр цэцэрлэг ажиллуулах;
- Дотуур байранд суух хүүхдийн тоог 2 дахин нэмэгдүүлэх;
- Оюуны багтаамж ихтэй, өндөр технологи эзэмшүүлэх зорилгоор залуучуудыг өндөр хөгжилтэй орнуудад сургах;
- Их, дээд сургуультай хоршсон эрдэм шинжилгээ, судалгааны төрөлжсөн байгууллага, салбар, мэдээллийн технологийн төвүүдийг байгуулж ажиллуулахыг урамшуулах;
- Бор-Өндөрт уул уурхай, барилгын үйлдвэрлэлийн нарийн мэргэжлийн ажилтан бэлтгэх төрөлжсөн коллеж шинээр байгуулах;
- Мэдээлэл-технологийн коллежийг шинээр байгуулах;
- Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн бүхий л хүрээнд инновацийг нэвтрүүлэх;
- Өндөр мэргэжилтэй багш нар, соёлын төвийн ажилтнуудыг орон нутагт ажиллуулах талаар эдийн засгийн урамшууллын шинэ хөшүүрэг бий болгох;
- Хувилбарт сургалт болон цэцэрлэгийн үндсэн сургалтанд хамрагдах хүүхдүүдийг бүрэн хамруулах;
- Жилд 8-аас доошгүй мэргэжлийн бус багш нарыг цэцэрлэгийн багшийн мэргэжил олгох сургалтанд хамруулах;
- Цэцэрлэгт зайлшгүй байх тоглоом, наадгайн нэр төрлийг олшруулан, гаднах тоглоомын талбайг өргөтгөх;
- Жаргалтхаан, Мөрөн, Батширээт, Баянмөнх, Дархан сумдад цэцэрлэгийн барилгыг шинээр барих;
- ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлэх;
- Өндөрхаан хотод хүүхэд залуучуудын парк байгуулах;
- Мөрөн, Өмнөдэлгэр, Галшар, Биндэр, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Норовлин сумдад спорт заал барих.

Стратегийн зорилт 2. Албан бус боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлнэ.

- Албан бус боловсрол олгох Зүүн бүсийн нэгдсэн сүлжээ бий болгох хөтөлбөрийг бүсийн аймгуудтай хамтран хэрэгжүүлэх;
- Албан бус боловсролын тогтолцоонд ажиллах орон тооны болон орон тооны бус багш бэлтгэх ажлыг дэс дараатайгаар хэрэгжүүлэх;
- Бичиг үсэг үл мэдэгч 40-өөс доош насныханд зориулсан бичиг үсгийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, хамран сургалтыг нэмэгдүүлэх;
- Дүйцсэн сургалтын хөтөлбөрөөр суралцагчдад хичээл заах АББ-ын нийт сумдын 24 багш нарыг бэлтгэх;
- АББ-ын чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, ажилагсдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх;
- АББ-ын орон нутгийн байгууллагуудыг бэхжүүлэх, Гэгээрэл төвүүдийн статусыг тодорхой болгох.

Стратегийн зорилт 3. Бүх шатны боловсролын сургуулиудын материаллаг баазыг бэхжүүлэн, удирдлагын менежментийг сайжруулна.

- Бага сургууль, цэцэрлэгийн тоглоом, наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний хангалтыг сайжруулах;
- Сургууль, цэцэрлэгүүдийн гал тогооны цахилгаан тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчлэн, эрүүл ахуйн стандартад нийцүүлэх;
- Жаргалтхаан, Дэлгэрхаан, Цэнхэрмандал сумын сургуулийг тойргийн сургууль болгон өргөжүүлэх;
- Хэрлэн, Жаргалтхаан сум, Бор-Өндөр, Бэрх тосгонд хүүхэд залуучуудын амралтын парк байгуулах;
- Норовлин суманд сургуулийн барилга шинээр байгуулах;
- Бор-Өндөр тосгонд сурагчдын дотуур байр шинээр барих;
- Дархан суманд соёлын төвийн өргөтгөл хийх, цэцэрлэгийн барилга, тоглоомын талбай барих;
- Дотуур байрны болон цэцэрлэгийн хүүхдийн хоолны төрөл, амт, чанарыг сайжруулж илчлэгийг стандартын хэмжээнд байлгах;
- Сургууль бүрийг хямд өртөгтэй, найдвартай ажиллагаа бүхий интернет номын сантай болгож, хүүхэд бүрт компьютер хөтөлбөрийг тус аймагт хүргэх;
- Боловсрол соёлын салбар дахь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжин урамшуулах;

- Гадаад орны мэргэжлийн төрөлжсөн байгууллагууд, хандивлагчдаас боловсролын салбарын материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийг бүх талаар дэмжих;
- Боловсрол, соёлын байгууллагын удирдлагын чадавхийг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх;
- Багш нарыг 100000 айлын орон сууцны хөтөлбөрт хамруулах, орон нутгийн төсвөөс багш нарт зориулан орон сууц барихад хөрөнгө хувиарлах, хувиараа орон сууц барихыг дэмжиж бага хүүтэй, урт хугацааны зээлд хамруулах;
- Зах зээлийн эрэлт хэрэгцээний дагуу хөрвөх чадвартай багш бэлтгэх;
- “Багшийг хөгжүүлэх хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлэх;
- ”Алсын зайны сургалтын төв”-ийг түшиглэн багш нарын мэргэжил дээшлүүлэх, зайны болон цахим сургалтын арга хэлбэрийг ашиглах;
- Мэдээллийн технологи ашиглан хичээл заах талаар багш нарт зориулсан сургалт зохион байгуулж, сургалтын материал, гарын авлагаар хангах;
- Шилэн кабелийн сүлжээ орсон сумдыг өндөр хурдны интернэтийн сүлжээнд холбох;
- Нүүдлийн номын сан ажиллуулах автомашинтай болгох.

Стратегийн зорилт 4. Урлаг, соёлын байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

- Сумдад соёлын төв, бичил бүсийн төвд урлаг-соёл-спортын төв, аймгийн төвд мэргэжлийн урлаг-соёлын хосолсон үйлчилгээтэй байгууллагууд ажиллуулах замаар соёлын үйлчилгээний оновчтой тогтолцоог бүрдүүлэх;
- Өндөрхаан хотод 800 хүний суудалтай театр шинээр барих;
- Сумдын номын сан, музей, театр, соёлын төвүүдийн байрны хангамж, материаллаг баазыг бэхжүүлэн үйлчилгээг өргөжүүлж, хүн амд мэдээлэл хүргэх төв болгон ажиллуулах;
- Аймгийн соёл, урлагийн байгууллагуудын менежментийг шинэчилж шилдэг боловсон хүчнээр хангах;
- Орон нутгийн судлах музейг 10 танхимтай болгох;
- Иргэдийн гар дээр байгаа соёлын өвийг музейн сан хөмрөгт авах.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн боловсролын тогтолцоо, сургалтын хэв шинжийг олон улсын нийтлэг жишигт хүргэнэ.

- Бүх нийтэд боловсрол эзэмшүүлэх Мянганы хөгжлийн зорилтыг бүрэн хэрэгжүүлэх;
- Мэргэжлийн сургалттай ахлах сургуулиуд байгуулах;
- Ерөнхий боловсролын сургуулиудын багш нарыг хөрвөх чадвартай болгох;
- Сургууль завсардалт болон бичиг үсэг үл мэдэх явдлыг бүрэн арилгах;
- Багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны ур чадварыг хөгжүүлж, нийгмийн хамгааллыг сайжруулах;
- Уул уурхай, биотехнологи, мэдээллийн технологийн чиглэлээр авьяастай залуучуудыг сонгон шалгаруулж, энэ чиглэлээр хөгжлийн өндөр түвшинд хүрсэн орнуудад төрийн зардлаар сургах;
- Нийт цэцэрлэгүүдийн тоглоомын хангалтыг нэмэгдүүлж, бүх цэцэрлэгт гадна тоглоомын талбай байгуулах;
- ЕБС-д сургуулиудад мэдээлэл зүйн лаборатори байгуулах;
- Төвийн бүсийн төв сургуулиудыг багш нарын мэргэжил дээшлүүлэх түшиц нэгж болгох;
- Нийт сургуулиудыг интернэтийн сүлжээнд холбох;
- Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөрөөр сургалт явуулах, багш нарыг бэлтгэх;
- Ядуу, эмзэг бүлгийхэн, ажилгүйчүүдэд боловсрол, мэргэжил олгох эрх зүйн орчныг хөдөлмөр эрхлэлтийн албатай хамтран гүйцэтгэх;
- Хөдөө орон нутгийн номын сантай дотоод сүлжээгээр холбогдох, фондын баяжилт хийх.

Стратегийн зорилт 2. Соёл урлагийн байгууллагуудын биеэ даан ажиллах оновчтой тогтолцоо бүрдүүлэн, үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлнэ.

- Сум дундын соёлын байгууллага байгуулж ажиллуулах;
- Урлагийн авьяастан, урчууд, уран бүтээлчдийг тодруулж дэмжих;
- Номын сан, архивын үйлчилгээг хүн амын эрэлт хэрэгцээнд нийцүүлэх;
- Иргэдийн гар дээр байгаа соёлын өвийг музейн сан хөмрөгт бүрэн авах.

3. 4. Эрүүл мэндийн хөгжлийн бодлого

Үндэслэл. 2008 оны байдлаар Хэнтий аймгийн эрүүл мэндийн салбарт 150 их эмч, 7 эм зүйч ажиллаж байгаа бөгөөд нэг эмчид 474, нэг сувилагчид 328 хүн ногдож байна. 2008 онд эмнэлэгт 17,0 мянган өвчтөн эмчлүүлжээ. Тус аймагт бүртгэгдсэн халдварт өвчин 1428, амьд төрсөн хүүхдийн тоо 713, амьд төрсөн 1000 хүүхэд тутамд ногдох нялхасын эндэгдэл 22,4, төрөхийн улмаас эндсэн эхийн тоо 2, үр хөндөлтийн тоо 460, 10000 хүн амд ногдох хорт хавдраар өвчлөлт, нас баралтын тоо 6, жирэмсэн эмэгтэйчүүдийн эмнэлгийн хяналтанд хамрагдсан хувь жирэмсний эхний 3 сартайд 85,5, 6 ба түүнээс дээш 97,8 хувь байна.

Хэнтий аймаг 23 спорт заалтай, спортоор хичээллэгчид 6918, биеийн тамираар хичээллэгчид 12849 хүн байна. Спортын цол зэрэгтэй тамирчид 3251, цол зэрэгтэй шүүгчид 201, улсын цолтой бөх 16, аймгийн цолтой бөх 286, сумын цолтой бөх 299, цолтой сур харваачид 36, цолтой уяачид 14 байна.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах орчин үеийн тогтолцоог цогц байдлаар бүрдүүлнэ.

- Аймгийн эрүүл мэндийн салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх;
- Аймгийн хүн амын өвчлөлийн байдлыг тогтоох судалгаа явуулж, эрүүл мэндийн байдлыг хянан тандаж мэдээлэх тогтолцоо бүрдүүлэх;
- Эрүүл аймаг, сум, баг болох санаачилгыг хөхүүлэн дэмжиж, иргэний нийгмийн байгууллага, хувь хүн, хамт олны оролцоог нэмэгдүүлэх;
- Олон улсын хөл хориот өвчнөөс аймгийн хүн амыг хамгаалахад чиглэсэн лаборатори, оношлогоо эмчилгээний явуулын багийн чадамжийг сайжруулах;
- Уламжлалт анагаах ухааны шилдэг аргыг эрүүл мэндийн үйлчилгээнд нэвтрүүлэх;
- Нэн ядуу, эмзэг бүлгийн хүмүүс, тахир дутуу иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх боломжийг нэмэгдүүлэх;
- Малчдад нүүдлийн өрхийн эмнэлгээр үйлчлэх тогтолцоо бүрдүүлэх;
- Хүн амын вакцинжуулалттыг 98-99 хувьд хүргэх;
- Халдварт өвчний гаралтыг 30 хувиар, хүүхдийн эндэгдлийг 2.5 промилоор бууруулах;

- Хүн амын хүрээлэн буй орчноос шатгаалсан өвчлөлийг 30 хувиар бууруулах;
- Өндөрхаанд халдвартын эмнэлэг шинээр барих, хүүхдийн хоол тэжээлийн сувилал байгуулах;
- Өндөрхаанд Зүүн бүсийн эмчилгээ оношлогооны төв байгуулж, оношлогоо эмчилгээний тоног төхөөрөмжөөр бүрэн хангах;

Стратегийн зорилт 2. Эрүүл мэндийн байгууллагын материаллаг бааз, боловсон хүчний хангамжийг сайжруулна.

- Аймгийн нэгдсэн эмнэлгийг стандартад нийцсэн барилгатай болгох;
- Аймгийн нэгдсэн эмнэлгийн орчин үеийн оношилгоо, эмчилгээний багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг сайжруулах;
- Аймгийн нэгдсэн эмнэлэг, орон нутгийн эмнэлэг, сум дундын эмнэлгүүдийг орчин үеийн эмчилгээ, оношлогооны тоног төхөөрөмжөөр тоноглогдсон автомашинаар хангах;
- Сумдын эмнэлгийн барилгыг шинэчлэх, шинээр барих;
 - Өмнөдэлгэр, Мөрөн сумын эмнэлгийн барилгыг шинээр барих;
 - Бор-Өндөр, Жаргалтхаан, Дэлгэрхаан, Баян-Овоо, Өлзийт, Гурванбаян сумын эмнэлгүүдэд их засвар хийх;
- Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын нийгмийн баталгааг сайжруулах, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох;
- Сумдын захиалгаар мэргэжлийн эмч бэлтгэх замаар эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлэх;
- Малчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор баг бүрт багийн эмчийг ажиллуулах;
- Дадал, Дэлгэрхаан, Бор-Өндөрт хүн ам, ахмад настанд зориулсан эмнэлэг сувилалын газар байгуулах;
- Ононгийн халуун рашаан, Жаргал нуурыг эмчилгээний зорижлалтаар тохижуулж ахмадын сувилал байгуулах.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Эрүүл мэндийн салбарын материаллаг баазыг бэхжүүлж, удирдлага, санхүүжилтийн нэгдмэл тогтолцоог хөгжүүлнэ.

- Мэдээллийн технологийн ололт амжилтыг эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх чиглэлээр тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх;
- Хувийн эмнэлгийн байгууллагуудыг дэмжин хөгжүүлэх;

- Аймгийн төвд биеийн тамирын дээд сургууль, сумдын төвд бялдаржуулах төв байгуулан ажиллуулах;
- Аймгийн төвд ахмад настанд зориулсан нөхөн сэргээх, асран сувилах газрыг байгуулж ажиллуулах;
- Тахир дутуу иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээг өргөтгөж материаллаг баазыг бэхжүүлэх;
- Хүн амыг зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслэлээр жигд, хүртээмжтэй тасралтгүй хангах;
- Нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлгийн байрыг засварлах, шинээр барих ажлыг эрчимжүүлэх.

ДӨРӨВ. ХЭНТИЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Хэнтий аймгийн хөгжлийн 2 дахь, 3 дахь, 4 дэх, 5 дахь тэргүүлэх чиглэлүүдийн хүрээнд 2010-2015 онд мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурийг тавьснаар нэг хүнд ногдох ДНБ-ийг 2548.2 мянган төгрөг болж 1,5 дахин өснө. 2016-2021 онд нэг хүнд ногдох ДНБ-ийг 3829.1 мянган төгрөгт хүрч 2,3 дахин нэмэгдэж мэдлэгт суурилсан, өөрөө өөрийгөө тэтгэдэг эдийн засгийг бий болгоно.

4.1. Макро эдийн засгийн бодлого

Үндэслэл: Хэнтий аймаг улсын ДНБ-ний 1.3 хувийг, Зүүн бүсийн 24.0 хувийг үйлдвэрлэж байгаа бөгөөд 2008 онд 80235,5 сая төгрөгийн ДНБ үйлдвэрлэснээс хөдөө аж ахуйн салбарт 71,3 хувь, аж үйлдвэр барилгын салбарт 2,5 хувь, үйлчилгээний салбарт 26,2 хувийг үйлдвэрлэжээ. 2008 оныг 2007 онтой харьцуулбал нэрлэсэн ДНБ 35,9 хувиар өсч, бодит ДНБ 18,5 хувиар буурчээ.

Тус аймгийн зээлийн өрийн үлдэгдэл 19853 сая төгрөг, иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 7711,1 сая төгрөг, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 332,9 сая төгрөг байна.

Хэнтий аймгийн орон нутгийн төсвийн орлого 4573,7 сая төгрөг, орон нутгийн төсвийн зарлага 4210,0 сая төгрөг, улсын төсвөөс орон нутагт олгосон санхүүгийн дэмжлэг 948,1 сая төгрөг байна. Аймгийн дотоодын барилгын байгууллагууд гүйцэтгэсэн барилга байгууламж, их засварын ажил 7651,5 сая төгрөг болжээ.

Хэнтий аймаг цахим тайлангийн системийг нэвтрүүлэх зорилгоор татвар төлөгчдөд сургалт явуулж, одоогийн байдлаар НӨАТ төлөгчдийн 40% нь, ААНАОТ, ХХОАТ төлөгчдийн 20% нь тайлангаа цахим хэлбэрээр өгч байгаа бөгөөд татварын төлбөрийг арилжааны болон төрийн сангаар дамжуулан гүйцэтгэж байна. Татвар төлөгчдөд утсаар зөвлөгөө өгөх тусгай томилсон ажилтангүй, харин нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан зөвлөгөө өгч байна.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Энэ үе шатанд ДНБ-ний жилийн дундаж өсөлтийг 9,4 хувьд хүргэж, аймгийн салбарын бүтцийг шинэчлэн аймгийн ДНБ-ий 19,3 хувийг уул уурхай, боловсруулах үйлдвэр, эрчим хүч, барилгын, салбарт, 67.4 хувийг ХАА-н салбарт, 13,3 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ.

- МAA-н түүхий эд, газар тариалангийн бүтээгдэхүүнийг бүрэн боловсруулах үйлдвэрүүдийг байгуулан экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийг тавих;
- Ашигт малтмалын томоохон ордуудыг түшиглэн уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулж ажиллуулах;
- Түүхий эдийн нөөцдөө тулгуурлан барилгын материалын үйлдвэрүүдийг байгуулж ажиллуулах;
- Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтөд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхүйц салбар болгох;
- Зам тээвэр, эрчим хүч, мэдээлэл холбооны дэд бүтцийг хөгжүүлж үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих, дотоод, гадаад зах зээлд гарах таатай орчин бүрдүүлэх;
- Улсын хилийн боомт, гарцын нэвтрүүлэн өнгөрүүлэх чадвар, үйлчилгээний чанарыг сайжруулж экспортын баримжаатай үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих;
- Төсвийн удирдлага, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох;
- Банк, санхүүгийн тогтолцоог боловсронгуй болгож, аймгийн хөгжлийг дэмжих сан байгуулж ажиллуулах;

- Үйлдвэрлэл, үйлчилгээнд мэдлэг, орчин үеийн менежмент, мэдээлэлийн технологийг тууштай нэвтрүүлэх;
- Татвар төлөгчдөд зориулсан өндөр хурдны интернэтэд холбогдох компьютеруудыг суурилуулах;
- Татварын төлбөрийг шуурхай болгох талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Энэ үе шатанд тус аймаг жилд 341844,0 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэж, нэг хүнд ногдох үйлдвэрлэлийн хэмжээ 2021 онд 3829,1 мянган төгрөгт хүрч 2009 онтой харьцуулбал 2,3 дахин нэмэгдэнэ. Аймгийн салбарын бүтцэд томоохон өөрчлөлт гарч ДНБ-ий 25,87 хувийг уул уурхай, боловсруулах үйлдвэр, эрчим хүч, барилгын салбарт, 35,05 хувийг ХАА-н салбарт, 39,08 хувийг үйлчилгээний салбарт тус тус үйлдвэрлэнэ.

- Үйлдвэрлэл, үйлчилгээнд орчин үеийн мэдлэг, менежмент, мэдээллийн технологийг эрчимтэй нэвтрүүлэх;
- Өндөр технологид тулгуурласан, экспортын баримжаатай, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх;
- Уул уурхайн салбарт эрдэс баялгийг боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх;
- Аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, аймгийн эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болгох.
- Татвар төлөгчид цахим тайлангийн системийг бүрэн ашиглаж хэвшсэн байх.

4.2. Эдийн засгийн бодит салбаруудын хөгжлийн бодлого

4.2.1. Аж үйлдвэрийн хөгжлийн бодлого

Үндэслэл: 2008 оны байдлаар Хэнтий аймгийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт борлуулалт 2383,8 сая төгрөг байв. Тус аймагт нийт 87 аж ахуйн нэгж жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаагаас Дотоодын үйлдвэрлэлийн борлуулалтаар 248.0 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, 26.1 сая төгрөгийн өргөн хэрэглээний бараа, импортоор 3991.2 сая төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, 190.8 сая төгрөгийн өргөн хэрэглээний барааны борлуулалт хийгджээ. Дотоодын үйлдвэрлэлийн борлуулалт нь импортын барааны борлуулалтын 6.55 хувьтай тэнцэж байна.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарын өнөөгийн байдлыг авч үзвэл

газар тариалангийн хувьд талбайн нөөц ашиглалт 36.4 хувьтай, сүүний нөөцийн хувьд 67.5 мянган толгой үнээ, 479.3 мянган толгой эм хонь, 371.1 мянган толгой эм ямаа, 51.0 мянган толгой гүү, 1.5 мянган толгой ингэтэй, харин мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөцийн хувьд 29.10 мянган тонн мах, 1625.6 тонн ноос ноолуур, 217.9 мянган ширхэг арьс ширийг боловсруулах боломжтой. Орон нутгийн онцлогоос хамааран аялал жуулчлалыг хөгжүүлэх, гар урлал, сувинер, цэцгий, буриад талх, бяслаг, ноосон эдлэл, арьсан дээрх зураг, гүзээн савхин эдлэл, модон эдлэл зэрэг нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бүсчилсэн байдлаар хөгжүүлэх боломжтой.

4.2.1.1. Боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд 2 дахин нэмэгдүүлж аймгийн ДНБ-ний 0,2 хувьд хүргэж экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийн үндэс суурийг тавина.

- Зах зээлд өрсөлдөх чадвартай хувийн хэвшилд тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээ, импортыг орлох үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Ноос, ноолуур, арьс шир, бодын хөөвөр хялгас, ногоо даршлах, сүү боловсруулах үйлдвэрүүдийг тэргүүн ээлжинд байгуулах;
- Мах боловсруулах бага, дунд оврын үйлдвэр байгуулж, дотоод, гадаад зах зээлд гаргах;
- Үйлдвэржилтийг дэмжих ажлын хүрээнд өдөрт 2 тн сүү үйлдвэрлэх хүчин чадалтай сүүний үйлдвэрийг Өндөххаан хотод байгуулах;
- Орчин үеийн технологиор хүнсний ногоо, жимс жимсгэнийг савлаж борлуулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, дотоод хэрэгцээгээ бүрэн хангах;
- Рашаан, ус савлан эмчилгээ сувилгааны чиглэлээр ашиглах;
- Өндөр технологи хэрэглэн аймагт түгээмэл тархсан барилгын материалын түүхий эдийг боловсруулж, цемент, барилгын бетон хийцүүд, тоосго, эрдэс будаг зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Эмийн үйлдвэр хөгжүүлэх;
- Аялал жуулчлалыг дагасан үйлдвэрлэл, үйлчилгээг бүх чиглэлээр хөгжүүлэх;
- “Нэг сум-нэг бүтээгдэхүүн” хөдөлгөөнийг эрчимжүүлэх;

- Өндөр технологи нутагшуулах төв байгуулан ажиллуулах;
- Өндөрхаан хотод хог хаягдал, хоёрдогч түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулах;
- Батширээт, Биндэр, Дадал суманд жимс, жимсгэнэ, хүнсний ногоо боловсруулах, савлах үйлдвэр байгуулах;
- Мах, махан бүтээгдэхүүн экспортлох.

Стратегийн зорилт 2. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай болгоно.

- Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх, өрхийн үйлдвэрлэлийг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн дэмжих, жижиг дунд бизнесийг дэмжих сан байгуулах;
- Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, бизнес инкубатор байгуулж ажиллуулах;
- Сүүний фермерийн аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- Малын гаралтай бүтээгдэхүүнийг борлуулах биржийн сүлжээ бий болгох;
- Цементийн үйлдвэр байгуулах;
- Норовлин, Баян-Адрага суманд сүү махны чиглэлийн үнээний эрчимжсэн загвар ферм байгуулах;
- Баян-Адрага, Биндэр, Норовлин сумдад малын тэжээлийн цех байгуулах;
- Бэрх тосгон, Галшар суманд ноос, ноолуурын цех, эсгийний үйлдвэр байгуулах;
- Батширээт суманд цаасны үйлдвэр байгуулах;
- Рашаан ус савлах, ингэний сүүг эмчилгээ сувилгааны чиглэлээр ашиглах нөхцлийг бүрдүүлэх;
- Жижиг дунд үйлдвэрлэгчдийг дэмжих инкубаторыг бүсчилсэн байдлаар сумдад байгуулах;
- Сумдад талх нарийн боовны цех байгуулах.

Хоёрдугаар үе шат (2016-2021он):

Стратегийн зорилт 1. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд 2016 онтой харьцуулахад 3,5 хувиар нэмэгдүүлж аймгийн ДНБ-ний 14,8 хувьд хүргэж экспортын баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлнэ.

- Экспортын баримжаатай, оюуны шингэц бүхий өрсөлдөх чадвартай, бага оврын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

- Мэдээлэл харилцааны технологи, түүний дотор хэрэглээний программ хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- Транзит тээвэр, санхүүгийн зуучлалын гэх мэт салбар дундын үйлчилгээг хөгжүүлэх.
- Сүү, сүүн бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалт, борлуулалтын зохистой сүлжээ бий болгох;
- Махны үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлж, олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх ААН-дийг дэмжих;
- Хүнс, худалдааны салбарт амжилттай үр бүтээлтэй ажилласан аж ахуй нэгжүүдийг урамшуулах.

4.2.1.2. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын ДНБ-ийг энэ үе шатанд жилд дунджаар 11.1 хувиар өсгөж, экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийг тавина.

- Ашигт малтмалын эрэл хайгуул, зураглалын ажлыг эрчимжүүлж 1:50000-ын масштабтай геологийн зураглал хийн, эхний ээлжинд ашиглах боломжтой эрдэс баялгийн нөөц тогтоох, хэрэглэх шаардлагатай олборлолтын технологид дүгнэлт гаргах, олборлох, боловсруулах ажилд хяналт тавих ажил хийх;
- Шинээр байгуулагдах уул уурхайн үйлдвэрүүдийн бүтээгдэхүүнийг хөрш орнуудад экспортлох;
- Ашигт малтмалын ордуудыг ашиглалтад оруулахад шаардлагатай дэд бүтэц, уурхайн цогцолборыг байгуулах асуудлыг дотоод, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх;
- Нүүрсний уурхайнуудыг түшиглэн шахмал түлшний үйлдвэр, хийн цахилгаан станц байгуулах, нүүрсийг коксжуулах ажлыг зохион байгуулах;
- Эрдэсийн түүхий эдийн боловсруулалтын түвшинг дээшлүүлж, эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран үйлдвэрүүдийн захиалгыг харгалзан уул уурхайн болон

барилгын материалын үйлдвэрүүдийн мэргэжилтэй ажилчдыг орон нутагт бэлтгэх;

- Дархан сумын нутагт буй Баргилтын төмрийн хүдрийн ордыг ашиглаж эхлэн цаашид баяжуулах үйлдвэр байгуулах;
- Хайлуур жоншны ордуудын олборлолтыг нэмэгдүүлэх замаар Бор-Өндөрийн болон Бэрхийн уулын баяжуулах үйлдвэрийн тогтвортой ажиллагааг хангах, бусад сумдад жижиг баяжуулах үйлдвэр байгуулах;
- Өмнөдэлгэрийн Мөнгөн-Өндөр /4.2 мян.тн мөнгө, 227 тн цайр, 286 тн хар тугалга/, Өндөрцагааны холимог металлын орд /175 мян.тн гянтболд, 26.0 мян.тн молибден, 7 мян.тн цагаан тугалга/-ыг байгаль орчинд хоргүй техник, технологиор ашиглаж эхлэх;
- Биндэр сумын Хөмөлийн алтны орд /P-45 тн/-ыг орчин үеийн боловсронгуй технологиор ашиглаж олборлох ажлыг судлаж шийдвэрлэх;
- Мөрөн сумын Чандганы нүүрсний орд /212.9 сая.тн/, Норовлин сумын Хулст нуурын нүүрсний орд /36.0 сая.тн/, Баянхутаг сумын Бүс овооны нүүрсний орд /227.9 сая.тн/-ын олборлолтыг эхлүүлж ойролцоох сумдын төв суурин газруудыг нүүрсээр бүрэн хангах.

Стратегийн зорилт 2. Уул уурхайн салбарт байгаль орчныг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хадгална.

- Уул, уурхайн ашиглалтад өртсөн талбайн нөхөн сэргээлтийг сайжруулах;
- Уурхайн олборлолтын технологид нэгдсэн стандарт мөрдүүлэх;
- Уурхайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, ашигт малтмалыг далд аргаар олборлох, газрын гүнд боловсруулалт хийхийг дэмжин өргөжүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас шалтгаалан гадаргын болон газрын доорхи усны экосистем доройтох, бэлчээр хомсдох зэрэг сөрөг нөлөөллийг багасгахад анхаарч экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор гол мөрний эх, айсаж, ойн бүс, нуур цөөрөм, түүхийн дурсгалт газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохгүй байх.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Геологи, уул уурхай, эрдэс баялаг, хүнд үйлдвэрийн салбарын ДНБ-ийг энэ үе шатанд жилд дунджаар 2.7 хувиар өсгөнө.

- Эрдэс, түүхий эдийн нөөцийг иж бүрэн ашиглах, хаягдалгүй, байгаль орчинд халгүй, өндөр технологийг нэвтрүүлэх;
- Эрдэс түүхий эдийн олборлолтыг хүчин чадлын хэмжээнд байлгаж, боловсруулалтын түвшинг ахиулж, эцсийн бүтээгдэхүүн гаргалтыг нэмэгдүүлэх;
- Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн цогцолборыг дагасан жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх;
- Уул уурхайн болон барилгын үйлдвэрлэлийн өндөр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх дээд сургууль байгуулах;
- Бэрх, Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн техник, технологийг шинэчилж, жонш олборлолт, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж уул уурхайн голлох үйлдвэр болгон хөгжүүлэх;
- Өмнөдэлгэрийн Мөнгөн-Өндөр, Өндөрцагааны холимог металлын ордуудын ашиглалтыг эхлүүлэн бүс нутгийн хэмжээний томоохон үйлдвэр болгон өргөжүүлэх;
- Өмнөдэлгэр сумын Навчит голын төмрийн хүдрийн орд /33.2 сая.тн/-ыг нарийвчлан судалж олборлох үйлдвэрийг барих ажлыг эхлүүлэх;
- Мөрөн сумын нутаг дахь урьдчилсан хайгуулаар 2 тэрбум тонн нөөцтэй нүүрсний ордыг түшиглэсэн нүүрснээс гүн боловсруулалт хийх замаар нефть химийн цогцолбор байгуулах, эх орныг нефтийн бүтээгдэхүүнээр хангах үйлдвэрийг барьж байгуулах, улмаар ОХУ, БНХАУ, БНСУ-д нүүрс экспортлох.

4.2.2. Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого

Үндэслэл: 2008 онд Хэнтий аймагт 2136.9 мянган мал тоологдсоноос адуу 143,3 мянга, хонь 1008,2 мянга, тэмээ 4.0 мянга, үхэр 158,6 мянга, ямаа 822,8 мянга байгаа бөгөөд үүнээс, нийт хээлтэгч мал 995,3 мянга, ингэ 1,2 мянга, гүү 43,3 мянга, үнээ 63,3 мянга, эм хонь 449,8 мянга, эм ямаа 389,7 мянган толгой байна.

Тус аймаг нийт 7445 малчин өрхтэй, 14463 малчидтай. Малчин өрхийн зарим үзүүлэлтүүдийг авч үзвэл цахилгаан үүсгүүртэй 4342, телевизортой 3609, авто машинтай 1839, мотоциклтэй 2187, трактортай 349 өрх байна.

Нийт мал сүргийн 85.7 хувийг бог мал, 14.3 хувийг бод мал эзэлж байна. Нэг малчин өрхөд 287, малтай нэг өрхөд 233 толгой мал ногдож байгаа нь улсын дунджаас 22-102 толгойгоор илүү байна. Нэг малчин өрх дунджаар 4 ам

бүлтэй бөгөөд 1 малчинд бодод шилжүүлснээр 40, толгойн тоогоор 148 мал ногдож байна. Иргэдийг малын бүлэглэлээр авч үзвэл, аминдаа малтай нийт өрхийн 66.1 хувь нь 200 хүртэл малтай, 20.8 хувь нь 201-500 малтай, 9,4 хувь нь 501-999 малтай, 3,7 хувь нь буюу 340 өрх 1000-аас дээш малтай, 17 өрх нь 2001-3000 хүртэл, 5 өрх 3000-аас дээш мал тоолуулсан бөгөөд 2008 онд мянгат малчин 59 хүнээр нэмэгджээ.

2008 онд 14 төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 169.9 сая төгрөгийн тарилга ийлдэс зарцуулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 1 сая 719.9 мянган мал хамрагдсан бол паразит өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 592.9 мянган мал хамрагдсаны гадна 40549 адуунд шинж тэмдгийн эмчилгээ хийж 57 багийн 1213 өрхийн 62433 адуунд томуугаас сэргийлэх вакцин хийжээ.

Хэнтий аймаг нь нийт 5369.5 мян.га бэлчээрийн эдэлбэр газартай үүнээс сул ба дунд зэрэг талхлагдсан газар 684192 га, хүчтэй талхагдсан 627300 га газар байна. Хэнтий аймаг 5,5 сая га бэлчээртэй, 100 га-д 77 толгой мал ногдож байгаа нь улсын дунджаас 31 толгойгоор их байна.

Хэнтий аймаг 90,2 мян.га эргэлтийн талбайтай үүнээс, үр тарианы зориулалтын 89.6 мянган га, төмс, хүнсний ногооны зориулалтын 568 га талбайтай.

2008 оны байдлаар газар тариалангийн салбарт 15 аж ахуйн нэгж, иргэн тариалангийн эргэлтийн талбайн 34 хувь буюу 30.8 мянган га талбайг эзэмшиж байна. Аймгийн хэмжээнд атаршсан 40.2 мянган га тариалангийн талбай байгаагийн 46 хувь нь буюу 21.6 мянган га талбайг тариаланд ашиглаж, үлдсэн 18.6 мянган га талбай нь салхины эвдрэлд хүчтэй орсон тул ашиглах боломжгүй байна.

Хэнтий аймаг 2008 онд 3476 га газар тариалалт хийснээс 2620 га-д үр тариа, 361,5 га –д төмс, 164,5 га-д хүнсний ногоо тариалж, үр тариа 2018,0 тн, төмс 2905,8 тн, хүнсний ногоо 1705,3 тн, малын тэжээл 41,2 мянган тн, байгалийн хадлан 85,0 мянган тн хураан авч аймгийн нийт хүн амын жилийн хэрэгцээний төмсний 74.7 хувийг, хүнсний ногооны 30 хувийг хангаж байна. Нэг га талбайгаас хураан авсан үр тариа 7,7 цн, төмс 80,4 цн байна.

Одоогийн байдлаар эрх бүхий Засаг даргын захирамжаар 7337 иргэн газар өмчлөх эрхээ аваад байгаа бөгөөд иргэдийн 9.3 хувь нь газраа үнэгүй өмчилж авчээ.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Өндөр өгөөжтэй бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулан, өндөр ашиг шимт малын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэн ХАА-н салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 6.1 хувиар өсгөнө.

- Хэнтий аймгийн мал аж ахуйг эрчимжүүлэн хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;
- Аймгийн сүргийн бүтцийн тэнцвэрийг зохистой хэмжээнд байлгах хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, чадавхийг оновчтой ашиглах, боловсруулах үйлдвэрийг зэх зээлийн эрэлтэд нийцүүлэн сум, сумдын дунд байгуулах;
- Малын тэжээлийн үйлдвэрүүдийг шинээр барьж ашиглалтад оруулах;
- Мянганы замын хэвтэй тэнхлэгийн дагуу болон тодорхой бүс нутгуудаар мах, сүүний чиглэлийн үхэр, ямаа, махны чиглэлийн хонь болон гахай, тахиа, зөгий, туулайн аж ахуй хөгжүүлэх;
- Өрхийн аж ахуйг хоршсон хэлбэрт шилжүүлсэн арга туршлагыг дэлгэрүүлэх;
- Мал эмнэлэг, үржлийн алба, үржлийн үйлчилгээний нэгжийн бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож, материаллаг баазыг бэхжүүлэн, мэргэжлийн боловсон хүчнээр хангах;
 - Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд 14 сая мал, паразит өвчнөөс эмчлэн сэргийлэхэд 3 сая толгой мал, лабораторийн тандах шинжилгээнд 150 мянган мал хамруулах;
 - Үүлдэр, омог, гойд ашиг шимт малыг богино хугацаанд өсгөхийн тулд биотехнологийн аргыг өргөн нэвтрүүлэх, бүсийн төвд малын үржлийн биологийн лаборатори байгуулах;
 - Малчдыг хөгжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх болон мал аж ахуй эрхлэх арга ухааны чиглэлээр малчдын дунд албан бус сургалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлэн хэрэгжүүлэх;
 - Жил бүр тэргүүний малчдын зөвөлгөөнийг төрөлжүүлэн явуулж, ажлын арга туршлагаа солилцох, суралцах, өндөр ашиг шимт мал олж авах, үржлийн шилмэл малаа сурталчилах зэрэг арга хэмжээ зохион байгуулах;

- Мэргэжилтний 30 хувийг шинэ залуу боловсон хүчнээр ханган аж ахуйн нэгжүүдийн материалаг баазыг бэхжүүлэн стандартын түвшинд ажиллуулах, малын эмч нарын 10 хувийг гадаад дотоодын сургалтанд хамруулан мэргэжил дээшлүүлэх;
- Мал эмнэлгийг тусгай зориулалтын ариутгалын автомашинаар хангах;
- Бэлчээрийг зохистой ашиглах, эзэмшүүлэх, сайжруулах, хамгаалах, талхлагдсан бэлчээрийг нөхөн сэргээх замаар багтаамж, даацыг нэмэгдүүлэн мал аж ахуйн эрсдэлийг бууруулах;
- Хүчтэй талхагдсан 627.3 мян.га бэлчээрийг сайжруулах, өнжөөх арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Мал өсгөх, үүлдвэр угсааг сайжруулах зорилтыг бэлчээрийн даац, ус, тэжээлийн хангамжтай уялдуулан төлөвлөх, зохицуулах;
- Бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох, тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, ган зудаас хамгаалах тэжээлийн байнгын нөөцийг бий болгох;
- Ашиглагдахгүй байгаа бэлчээрт худаг гаргах, хурын ус хуримтлуулах, булаг шандны усыг хамгаалах замаар усжуулалтын хэмжээг нэмэгдүүлэх.

Стратегийн зорилт 2. Газар ашиглалтыг сайжруулж, усалгаатай тариаланг хөгжүүлэн, биотехнологи нэвтрүүлэх замаар газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ.

- Аймгийн хэмжээнд байгаа агрономич, механикжуулагч мэргэжилтнүүдийг давтан сургалтад хамруулах, шинээр боловсон хүчин бэлтгэх;
- Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран сумдын захиалгын үндсэн дээр мэргэжилтэй ногоочид, тракторч-фермерийн сургалт, дамжаа байгуулах;
- Атаршсан талбайн судалгааг сум бүрээр гарган ашиглах боломжтой талбайн хэмжээ, хөрсний үржил шимийн судалгаа хийж, нийт эргэлтийн талбайг 4.5 дахин, төмсний талбайг жилд 50 га-гаар, хүнсний ногооны талбайг жилд 5 га-гаар нэмэгдүүлэх;
- Сэлгээнд зориулж хөх тариа, шар буурцаг, арвай, хошуу будаа, царгас, эрдэнэшиш, вандуй зэрэг үр тариа, тэжээлийн ургамлын үр үйлдвэрлэсэн аж ахуйн нэгж, иргэдэд дэмжлэг үзүүлэх;

- Услалтын оновчтой системийг бий болгох, усалгаатай газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг лизингээр олгох, усжуулалтын барилга байгууламжийн эзэмшилт, ашиглалтыг сайжруулах;
 - Нийт тариалах талбайн хэмжээг 25.0 мянган га-д хүргэх;
 - Аймгийн хүн амын төмс, хүнсний ногооны жилийн хэрэгцээний 80 хувийг хангах;
 - Хэрлэн суманд 1 га хүлэмжийн аж ахуй байгуулах;
- Газрыг бүсчилэн эдийн засгийн эргэлтэнд оруулж, түүнээс олох орлогыг нэмэгдүүлэх.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Биотехнологийг тууштай нэвтрүүлж, малын үүлдэрлэг чанарыг сайжруулж, тарималын ургацыг нэмэгдүүлэн ХАА-н салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дундажаар 3.8 хувиар өсгөнө.

- Биотехнологи ашиглаж, малын эм, ариутгал, халдваргүйжүүлэгч бэлдмэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлэн мал сүргийг эрүүлжүүлэх;
- Усалгаатай газар тариалангийн орчин үеийн технологийг өргөн нэвтрүүлж, 1 га-аас авах ургацыг нэмэгдүүлэх;
- Хөдөө аж ахуйг харилцан бие биенээ тэтгэсэн бүтэц бүхий хөдөө аж ахуй, үйлдвэрийн цогцолбор болгон хөгжүүлэх;
- Малчдын түлш, эрчим хүчний хангамжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.
- Сул ба дунд зэрэг талхагдсан 682.3 мянган га бэлчээрийг сайжруулах, сэлгэн ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Бэлчээр усжуулалтын ажлыг өргөжүүлэх;
- Тэжээлийн таримал ургамал үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
- 10 сая малыг халдварт өвчнөөс, 6 сая малыг паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх, 300 мянган толгой малд лабораторийн тандах шинжилгээ хийх;
- Аймгийн төмс, хүнсний ногооны жилийн хэрэгцээг бүрэн хангах;
- 70.0 мянган га тариалангийн эргэлтийн талбайг бүрэн ашиглах;
- Малыг эмч, мэргэжилтэн нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хөрвөх чадвартай боловсон хүчнээр хангах.

4.2.3. Аялал жуулчлалын хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Аялал жуулчлалын салбарын жилийн дундаж өсөлтийг 30.5 хувьд хүргэж эдийн засгийн биеэ даасан тэргүүлэх салбарын нэг болгоно.

- Хэнтий аймгийн аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх;
- Аймгийн аялал жуулчлалын маршрутыг Зүүн бүсийн бусад аймгийн аялал жуулчлалын маршруттай холбон Хамтын аялал жуулчлал (Community based tourism)-ыг хөгжүүлэх;
- Өмнөдэлгэр, Биндэр, Батширээт, Дадал сумдыг хамруулсан "Чингис хаан" цуврал цогцолбор байгуулах;
- Аймгийн аялал жуулчлалын лавлах, танилцуулга гарган, интернетэд ВЭБ хуудас нээн ажиллуулах;
- Ононгийн халуун ус, Аварга тосон, Гурван нуур, Ононгийн Тарсын рашааныг хамарсан рашаан сувиллын сүлжээ байгуулах;
- Онон, Тарсын зэрэг халуун рашааныг түшиглэн өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж эхлэх;
- Аялал жуулчлал хөгжүүлэх бүсүүдэд дотоод, гадаадын жуулчид, анчдыг хүлээн авах олон улсын зэрэглэлийн зочид буудал, жуулчдын бааз, түр буудаллах дэн буудлын сүлжээ байгуулахыг дэмжих;
- Аяллын тогтоосон маршрутын дагуух автозамыг засварлах, тэмдэгжүүлэх;
- Жуулчдын баазын ойролцоо угсаатны зүйн болон уламжлалт зан үйлийг сонирхуулах, эмнэг мал сургах, эсгий хийх, цагаан идээ боловсруулах, морин аялал хийх, үзэсгэлэн гаргах зэрэг арга хэмжээ явуулах.

Стратегийн зорилт 2. Аялал жуулчлалын материаллаг баазыг бэхжүүлэн, менежментийг боловсронгуй болгоно.

- Аялал жуулчлалын маршрутын дагуух түүх, соёлын үнэт зүйлсийг сэргээн засварлах;
- Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Баян-Адарга, Дадал, Өндөрхаанд орчин үеийн зочид буудал, зоогийн газар шинээр байгуулах, үйлчилгээний стандартыг олон улсын жишигт ойртуулах;
- Өмнөдэлгэр-Биндэр-Баян-Адарга-Дадал чиглэлийн автозамыг сайжруулах, Өндөрхаан-Бэрх-Батноров-Норовлин-Дадал чиглэлийн автозамыг хатуу хучилттай болгох ажлыг эхлүүлэх;
- Аймгийн орон нутгийн болон угсаатны зүйн музейн сан хөмрөгийг

- арвижуулах, жуулчдын сонирхлыг татахуйц үзмэрүүдийг шинээр бий болгох;
- Аймаг, сумдад аялал жуулчлалын анхан шатны менежмент, гадаад хэлний сургалт явуулах;
- Өмнөдэлгэр сумын Балдан бэрэйвэн хийдийг бүрэн сэргээж, ашиглах;
- Эзэн Чингис хааны түүхтэй холбоо бүхий 40 дурсгалт газрыг хамгаалах, тодруулах, сэргээн засварлах, хамгаалалтад авах;
- Эрчим хүчний эх үүсвэрээр жуулчны үйлчилгээний газруудыг хангах.

Хоёрдугаар үе шат (2016 – 2021 он):

Стратегийн зорилт 1. Аялал жуулчлалын салбарын жилийн дундаж өсөлтийг 35.4 хувьд хүргэж, үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэнэ.

- Улсын аялал жуулчлалын мастер төлөвлөгөөтэй уялдуулан гадаад улсад сурталчлах замаар аймгийн аялал жуулчлалыг олон улсын болон Зүүн хойд Азийн аялал жуулчлалын сүлжээнд хамруулах;
- Эзэн Чингисийн онгоныг байгуулан, түүнийг тойрсон аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Хан Хэнтийн байгалийн үзэсгэлэнт газарт загас барих, ан амьтныг харуулах зорилгоор байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх;
- Өвлийн аялал жуулчлалын цогцолбор баазуудыг байгуулан Зүүн хойд Азийн аялал жуулчлалын сүлжээнд хамруулах;
- Өндөрхаанд өндөр зэрэглэлийн зочид буудлыг байгуулах;
- Аялал жуулчлалын бүх төрлийн үйлчилгээний чанарыг сайжруулж олон улсын стандартад нийцүүлэх;
- Аялал жуулчлалын ажилтнуудын боловсрол, сургалтын түвшинг олон улсын жишигт хүргэн, тус салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох.

4.3. Дэд бүтцийн хөгжлийн бодлого

Үндэслэл: Хэнтий аймагт 2008 оны байдлаар 3407 авто машинтай, үүнээс, суудлын машин 1910, ачааны машин 1265, автобус 160, цистерн 14, тусгай зориулалтын машин 58 байна. 2008 онд Хэнтий аймаг 2005 оны тооцсон үнээр 186,6 сая төгрөгийн цахилгаан, дулаан үйлдвэрлэжээ. Тус аймгийн суурин телефон цэгийн тоо 2176 байна.

4.3.1. Зам, тээврийн хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Аймгийн авто замын сүлжээг сайжруулж зарим замыг хатуу хучилттай болгоно.

- Жаргалтхаан сумаас Өмнөдэлгэр сум руу 55 км, Дэлгэрхаан сум руу 45 км засмал зам тавих;
- Цэнхэрмандал-Биндэр-Дадал чиглэлийн замыг хайрган хучилттай болгох;
- Автозамын салбарыг хөгжүүлэхэд утас, орон нутгийн төсвийн хөрөнгөөс гадна гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн хэвшлийн оролцоог бүх талаар дэмжих;
- Аймгийн автозамын нэгдсэн сүлжээний зураглалыг шинэчлэн боловсруулах;
- Өндөрхаан хот доторхи хатуу хучилттай замыг шинэчлэн сайжруулах;
- Зам, гүүрийн барилгын техник хэрэгслийн хангамжийг урт хугацааны бага хүүтэй зээл (лизинг)-ээр дэмжих.

Стратегийн зорилт 2. Агаарын тээврийн үйлчилгээг өргөтгөн сайжруулна.

- Агаарын тээврийн үйлчилгээний хүртээмж, тогтвортой, найдвартай байдал, ая тухыг бүрдүүлэх;
- Онгоц хөөрөх, буух зурвасыг шинэчлэн сайжруулж, хатуу хучилттай болгох;
- Өндөрхаан хотын нисэх буудлыг хатуу хучилттай болгон олон улсын жишигт нийцүүлэн байгуулах.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Автозамын сүлжээг өргөтгөн, агаарын тээврийг эрчимтэй хөгжүүлнэ.

- Олон улсын зорчигч болон ачаа тээврийн онгоц хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх;
- Бусад аймгийн төвүүдтэй хатуу хучилттай замаар холбогдох ажлыг дуусгах.
- Бор-Өндөр - Баруун-Урт – Тамсаг - Чойбалсан чиглэлийн төмөр замаар БНХАУ-тай төмөр замаар холбогдох;
- Өндөрхаанаас Дадал сум руу 270 км засмал зам тавих.

4.3.2. Эрчим хүчний салбарын хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг энэ үе шатанд жилд дунджаар 9.7 хувиар өсгөж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чадвартай эрчим хүчний салбарыг бий болгоно.

- Эрчим хүчний салбарын шинэчлэл, хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлж сумдын халаалтын тогоонуудад шинэ дэвшилтэт техник технологи нэвтрүүлж, тоног төхөөрөмжийг нь иж бүрэн шинэчлэх;
- Эрчим хүчний салбарт хэрэгжүүлэх шаардлагатай төслүүдийг хувийн хөрөнгө оруулалт татах замаар шийдвэрлэх;
- Өндөрхаанд дулааны цахилгаан станц байгуулах.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Эрчим хүчний менежментийг боловсронгуй болгож, байгаль орчинд халгүй тэргүүний техник технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашгийг дээшлүүлнэ.

- Эрчим хүчний хангамжийг өртөг багатай, найдвартайгаар зохион байгуулахын тулд бага оврын халаалтын зуух бүхий хэрэглэгчдийг сумдад дулааны эрчим хүчний нэгдсэн системтэй болгох;
- Аймаг, сумдын нэвтрүүлэх чадвар нь хүрэлцэхгүй байгаа, хуучирсан дулааны шугам сүлжээг өргөтгөх;
- Хөдөөгийн малчин айл өрхийн 90-ээс доошгүй хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах ажлыг дэс дараатай хэрэгжүүлэх;
- Барилга байгууламжид өргөнөөр ашиглагдаж байгаа нарны илчээр ус, агаар халаах арга, технологи, тоног төхөөрөмжийг хэрэглээний халуун ус болон бусад зориулалтаар өргөн ашиглах;
- Нүүрснээс утаагүй түлш үйлдвэрлэх бага оврын үйлдвэрүүд байгуулж ажиллуулах.

4.3.3. Мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжлийн бодлого

Нэгдүгээр үе шат (2010 – 2021 он):

Стратегийн зорилт 1. Мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, сүлжээг шинэчлэх замаар “Мэдээлжсэн нийгэм”-ийг байгуулах суурь үндсийг бүрдүүлнэ.

- “Цахим Монгол” хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг аймаг, сумдад бүрэн хэрэгжүүлэх;
- Хэвлэлийг электрон хэлбэрээр хүргэж, хэвлэх ажлыг зохион байгуулах;
- Аймгийн хэмжээнд бүх нийтийн компьютержүүлэлт, өрх бүрт интернет дэд хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх;
- Бүх сумдын төвд интернет цэг, интернет кафе байгуулж үйлчлэх;

- Бүсчлэлийн нэгдсэн (ZIP) кодыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэрэглээ болгох;
- Бүх сумдад 10-аас доошгүй сувгийн телевизийн нэвтрүүлэг үзэх боломж нөхцлийг бүрдүүлэх;
- Орон нутгийн телестудийг аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан мэргэжлийн телевиз болгон хөгжүүлэх.

Стратегийн зорилт 2. Аймаг сумдын мэдээлэл, харилцаа холбооны дамжуулах сүлжээг шилэн кабель, сансрын холбоо, радио холбоогоор шинэчлэнэ.

- Бүх сумдын төвд утасгүй холбоо, үүрэн телефон, интернетийн үйлчилгээг нэвтрүүлэх;
- Шуудан холбооны сүлжээг ашиглан орчин үеийн шинэ төрлийн электрон үйлчилгээ болон хэрэглээг нэвтрүүлэх, с ум ба багийн шуудан хүргэлтийн давтамжийг нэмэгдүүлэх;
- Аймаг ба сумын дамжуулах болон холбох байгууламжийг тоон технологид бүрэн шилжүүлэх.

Стратегийн зорилт 3. Мэдээлэл, харилцаа холбооны шинэ үйлчилгээ хэрэглээг төр, аж ахуйн болон үйлчилгээний бүхий л байгууллагуудад өргөн нэвтрүүлнэ.

- Аймгийн төвийн төр, захиргаа, аж ахуйн нэгж байгууллагыг нэгдсэн сүлжээнд холбож, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Аймгийн төв, зарим сумдын төвийн эмнэлэг, сургуулийг мэдээлэл, харилцаа холбооны нэгдсэн сүлжээнд холбох;
- МХХТ–ийн олотыг төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, оролцоог нэмэгдүүлэх хэрэгслэл болгох;
- Электрон засаглал, электрон арилжаа, электрон гарын үсэг, шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэхэд бүх шатанд холбогдох салбарын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх.

Стратегийн зорилт 4. Аймгийн хэмжээнд мэдээлэл, харилцаа холбооны мэргэжилтэн бэлтгэх чадавхийг бүрдүүлэн, хүний нөөцийг хөгжүүлнэ.

- Мэдээлэл, холбооны хэрэглээ, үйлчилгээг бага насны хүүхэд, өндөр настан, эмэгтэйчүүд болон нийгмийн эмзэг бүлэгт хүргэх сургалтын арга хэмжээ зохион байгуулах;

- МХХТ-ийн өндөр ур чадвартай мэргэжлийн боловсон хүчин, инженер, техникийн ажилтнуудыг бэлтгэх, давтан сургах, улмаар гадаад орнуудад гэрээгээр ажиллах нөхцлийг бүрдүүлэх.

4.4. Хот байгуулалт, барилгын салбарыг хөгжүүлэх бодлого

Үндэслэл: Хэнтий аймгийн хувьд 2008 оны байдлаар дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил 7651,5 сая төгрөгт хүрчээ. Барилгын материалын үйлдвэрлэлийн түүхий эдийн нөөцтэй.

Зүүн бүсэд барилгын материалын 30 ордын нөөцийг тогтоосноос барилгын чулууны 5, тоосгоны шаврын 5, шохойн чулууны 5, барилгын элсний 11, элс хайрганы хольцын 1, перлитийн 1, галт уулын шаарны 1, керамзитын шаврын 1 орд байна. Аймгийн хэмжээнд байгалийн түгээмэл баялаг болох барилгын элс, хайрганы нөөц элбэгтэй. Мөрөн, Өмнөдэлгэр сумдууд шохойн чулууны нөөц, Баянхутаг сумын Сондуулт, Хавтгарын тоосгоны шаврын орд 30-40 жилийн нөөцтэй.

Нэгдүгээр үе шат (2010-2015 он):

Стратегийн зорилт 1. Өндөрхаан хотыг батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу эрчимтэй хөгжүүлнэ.

- Өндөрхаан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- Сум бүрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг орчин үеийн хот байгуулалтын бодлоготой уялдуулан боловсруулах;
- Ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтцүүдийг сайжруулах;
- Аймгийн төв, сум болон бусад томоохон суурин газрыг дулаан, цэвэр ус, ариутгах татуургын нэгдсэн системтэй болгох;
- Биндэр, Цэнхэрмандал, Норовлин сум, ХБУ тосгонд сургуулийн барилгыг шинээр барих;
- Батноров, Галшар, Бор-Өндөр, Хэрлэн сумын сургуулийн дотуур байрны барилга барих, цэвэр, бохир усан хангамжийг сайжруулах;
- Бор-Өндөр болон Хэрлэн 1-р сургуулийн дотуур байранд өргөтгөл хийх;
- Баян-Овоо, Хэрлэн сумын 4-р сургууль, Бэрхийн сургууль, Хэрлэн сумын Тахилгат тосгоны бага сургууль, дотуур байрыг засварлах;
- Баян-Овоо, Дадал, Батширээт, Жаргалтхаан, Дархан, Баянмөнх сум, Хэрлэн сумын 2-р багийн цэцэрлэгийн барилгыг шинээр барих, Баянхутаг, Мөрөн сумын цэцэрлэгийн барилгад их засвар хийх;

- Орон нутаг судлах музейн барилгыг шинээр барих;
- Хан Хэнтий театр, Цэнхэрмандал, Баян-Овоо, Дадал, Норовлин сумдын соёлын төвийн барилгыг шинээр барих, Хэрлэн-Баян-Улаан, Дархан, Батширээт сумдын соёлын төвүүдийн барилгыг өргөтгөх, Төв номын сан, Гурванбаян, Өмнөдэлгэр, Бэрх, Бор-Өндөр, Баянхутаг сумдын соёлын төвийн барилгад их засвар хийх;
- Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг дуусгах;
- УАУТөв, Халдвартын эмнэлэг, Өмнөдэлгэр сумын эмнэлэгийн барилгыг шинээр барих;
- Аймгийн нэгдсэн эмнэлэг, Мөрөн Жаргалтхаан, Баян-Овоо, Дэлгэрхаан сум, Өлзийт, Тахилгат, Гурванбаян, Бор-Өндөр, тосгоны эмнэлгийн барилгуудад их засвар хийх;
- ХХААЖДҮГ-ын конторын барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах;
- Цэнхэрмандал, Дархан сумын ЗДТГ-ын конторын барилгыг шинээр барих;
- Өмнөдэлгэр, Батширээт, Батноров, Норовлин суманд улсын хөрөнгө оруулалтаар, Галшир суманд орон нутгийн хөрөнгө оруулалтаар “Кабон” барилга барих;
- Өндөрхаан-Дадал чиглэлийн 270 км хатуу хучилттай автозамын ажлыг эхлүүлэх;
- Өндөрхаан-Сүмбэрийн чиглэлийн авто замыг улсын хөрөнгө оруулалтаар барих ажлыг үргэлжлүүлэх;
- Өндөрхаан хотын дотор 7,5 км автозамыг хатуу хучилттай болгож, гарц, тэмдэг, тэмдэглэгээг нэмэгдүүлэх;
- Баянмөнх сумын нутагт Хэрлэн гол дээр гүүр шинээр барих, Өмнөдэлгэр сумын Хурх, Батширээт сумын Бархын голын гүүрүүдийг засварлах;
- Өндөрхаан хотод Дулааны станц байгуулж, хотын бүх орон сууцыг хэрэглээний халуун усаар хангах, дулааны болон усан хангамжийн шугам сүлжээнд их засвар хийх;
- 150 айлын орон сууц барьж ашиглалтад оруулах.

Стратегийн зорилт 2. Орон нутгийн түүхий эд, байгалийн баялагт тулгуурласан барилгын материалын үйлдвэрүүдийг бий болгоно.

- Барилга, барилгын материалын судалгааны Зүүн бүсийн төв байгуулах;
- Аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн 1:50000–ын масштабын, шаардлагатай тодорхой бүсэд улам нарийвчилсан судалгаа

хийж барилгын материалд ашиглах боломжтой түүхий эдийн орд, илрэцийг нээж, нэр төрөл, чадавхийг тогтоох;

- Шинээр нээгдсэн болон нарийвчилсан хайгуул хийгдсэн орд газруудын түүхий эдийг ашиглан шинэ нэр төрлийн барилгын материалын үйлдвэрлэл зохион байгуулах;
 - жилд 10 сая хүртэл тоосго үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулах;
 - олон төрлийн цонх үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулах;
 - цементийн үйлдвэр байгуулах;
 - хөөсөн полистрол хавтан, шилэн багцтай цонх, хаалга, дээврийн элс-цементэн хавтанцар, ханын бетон гулдмай, өнгөлгөөний материалын бага, дунд хүчин чадлын үйлдвэр байгуулах;
 - элс, хайрга бутлан ангилах, цементэн зуурмаг, бетон, төмөрбетоны орчин үеийн үйлдвэр, цехүүдийг байгуулах;
 - шохой, гөлтгөнөт эдлэхүүн, эрдэс будгаар зам талбай, засал чимэглэл, тохижилтийн жижиг бүтээц эдлэлийн үйлдвэр байгуулах;
- Дүүргэгч материалын нэгдсэн карьер, бетон зуурмагийн төвлөрсөн узел ажиллуулах;
- Барилгын материалын сорьцын лабораториудыг байгуулах;
- Сумдын барилгын засварын ажил гүйцэтгэх чадамжийг нэмэгдүүлэх.

Стратегийн зорилт 3. Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан аймгийн орон сууцны хангамжийн түвшинг сайжруулна.

- “100000 айлын орон сууц” хөтөлбөрийн хүрээнд аймгийн төвд нягтруулсан орон сууцны шинэ хороолол бий болгох;
- “Орон сууц” сан бүрдүүлж, эн түрүүнд төрийн албан хаагчид, залуу гэр бүлийг орон сууцаар хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Амины орон сууц барьж буй иргэдийг хөнгөлөлттэй зээлд хамруулах, орон сууцны санхүүгийн эх үүсвэрүүдийг бий болгох;
- Гэр хорооллыг цэвэр, бохир усны шугам сүлжээнд холбох;
- Инженерийн шугам сүлжээтэй орон сууцанд амьдарч байгаа хүн амын эзлэх хувийг 8 хувьд хүргэх.

Хоёрдугаар үе шат (2016-2021 он):

Стратегийн зорилт 1. Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан иргэдийн орон сууцны хангамжийн түвшинг дээшлүүлнэ.

- Орон сууц хангамжийн талаар мэдээллийн сан бий болгох;
- Аймгийн төв, сумдын бага орлоготой болон залуу гэр бүлийг орон сууцаар хангах дэд хөтөлбөрийн хэрэгжүүлэх;
- Төрийн албан хаагчдад зориулсан орон сууцны хоёр дахь шатны төсөл хэрэгжүүлэх;
- Орон гэргүй иргэдийг орон байраар хангах цогц арга хэмжээ авах;
- Барилгын материалын үйлдвэрлэлд шинэ техник, технологийг нэвтрүүлж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулан, нэр төрлийг нь олшруулах;
- Орон сууц барихад улсын болон хувийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, орон сууцны зээлийн системийг өргөтгөх.

ТАВ. ХЭНТИЙ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО

Хэнтий аймгийн хөгжлийн 6 дахь тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараахь стратегийн зорилтуудыг хэрэгжүүлнэ.

Үндэслэл: Хэнтий аймгийн цаг уурын олон жилийн дундаж үзүүлэлтийг авч үзвэл, тунадас 259,4 мм, агаарын температур 1 дүгээр сард -23,4 хэм С⁰, 7 дугаар сард 18,7 хэм С⁰, 2008 оны байдлаар гарсан ойн түймэр 6, ойгоос бэлтгэсэн мод 18,7 мянган м³, гол горхи 255, булаг шанд 611, рашаан 18, нуур тойром 288 байна. Агаар дахь бохирдуулагч бодисын жилийн дундаж агууламж 0,004 мкг/м³ байна.

Хэнтий аймагт монгол орны ой модны 11 хувь байдаг бөгөөд 2005 оны судалгаагаар аймгийн нутаг дэвсгэрийн 1783.9 мянган га-г ойн сан эзэлж байна. Сүүлийн 10 жилд 135 удаагийн түймрээр 2.6 сая га бүхий талбай шатаж 175 сая төгрөгийн хохирол учирчээ. 2008 онд ойн санд учирсан хохиролын хэмжээг 2007 онтой харьцуулахад түймэрт нэрвэгдсэн ба өвчин, хортон шавжид идэгдсэн ойн талбай бараг 2 дахин нэмэгджээ.

Хэнтий аймаг нь нийт 5369.5 мян.га бэлчээрийн эдэлбэр газартай бөгөөд бэлчээрийн 1 га-гийн ургац аймгийн дунджаар 2.4 цн байна. Үүнээс сул ба дунд зэрэг талхлагдсан газар 684192 га, хүчтэй талхагдсан 627300 га газар байна.

Бүх үе шат (2010-2021 он):

Стратегийн зорилт 1. Байгаль орчны бохирдол, доройтлыг сааруулна.

- Аймаг, сумдын байгаль орчны мэдээллийн иж бүрэн сан бүрдүүлэх;

- Байгаль орчинд учруулсан хохирлын эдийн засгийн үнэлгээний дагуу нөхөн сэргээх бодлого хэрэгжүүлэх;
- Сэргээгдэх эрчим хүч ашиглах хувь хэмжээг нэмэгдүүлж, нар, салхи, усны эрчим хүчний эх үүсвэрийн дан болон хоршсон хэрэглээг хөгжүүлэх;
- Айл өрх, албан байгууллагын хашаа, эзэмшил газар, нийтийн эзэмшлийн газруудыг цэцэрлэгжүүлэх, зүлэгжүүлэх ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх, агаарын физик-химийн хортой нөлөөллийг бууруулах;
- Хот, суурин газрын хатуу хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, ялган ангилах, дахин боловсруулах, эргүүлж ашиглах, байгальд халгүй аргаар устгахад шинэ технологи, менежмент нэвтрүүлэх;
- Орон нутгийн эко-системийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдолтой бүхий газруудыг улс, аймаг орон нутгийн хамгаалалтад авах.

Стратегийн зорилт 2. Газар ашиглалтын оновчтой тогтолцоо бүрдүүлнэ.

- Газар ашиглалтын төлөв байдал, үржил шимийг дээшлүүлэх, түүнчлэн стандартын холбогдолтой мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх оновчтой тогтолцоо бий болгох;
- Газрын нөөцийн менежмент, газар зохион байгуулалтыг сайжруулах;
- Уул уурхайн үйлдвэрлэл, хайгуул болон ашиглалтын үйл ажиллагааны уршгаар бий болсон хохиролыг арилгах, түүнтэй тэмцэхэд нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагын хүчийг нэгтгэн зохион байгуулах;
- Химийн хорт бодисоор бохирдсон газар нутгийн хөрс, усыг хоргүйжүүлэх;
- Байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгалт газар, нэн ховор, ховордсон ан амьтан, ургамлын тархац болон аялал жуулчлал, эрчимжсэн МАА-н үйлдвэрлэл хөгжүүлэх бүс нутаг, ашигт малтмалын илрэл бүхий хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдоогүй газруудыг аймгийн тусгай хэрэгцээ, хамгаалалтад авах;
- Тариалангийн эргэлтээс хасагдаж байгаа талбайн хөрсний эвдрэлийг зогсоож, олон наст ургамлын үр тарих, бэлчээрийн нөөцөд шилжүүлэх арга хэмжээ авах;
- Инженерийн хийцтэй уст цэгийг засварлах, шинээр гаргах ажлыг жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, бэлчээр, усжуулалтын түвшинг дээшлүүлэх;

- Хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, тариалангийн талбайг тойруулан ойн зурвас байгуулах, мөн таримал болон тэжээлийн, эмийн ургамал тариалах замаар ашиглах.

Стратегийн зорилт 3. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах, хүн амыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах нөхцлийг бүрдүүлнэ.

- Төв, суурингийн усны бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөгөөтэй хэрэгжүүлэх;
- Хүн амын ундны усыг зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх бага оврын тоног төхөөрөмжийг сумдад нэвтрүүлж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усны хэрэглээг нэмэгдүүлэх;
- Бэлчээрийг усжуулж, экологийн тэнцвэрт байдалд сөрөг нөлөөгүй услалтын системүүдийг газар тариаланд ашиглах;
- Хурын усыг хуримтлуулж хөв, цөөрөм байгуулах асуудлыг судалж хөдөө аж ахуй, газар тариаланд ашиглах ажлыг судалж хэрэгжүүлэн усны нөөцийг хамгаалах;
- Усны нөөцийг зохистой ашиглах хамгаалах, нөөц чанар доройтохын хор уршгийн талаар олон нийтийг хамруулсан сурталчилгааны ажил зохион байгуулах;
- Усны эх үүсвэрийг бохирдох, хомсдохоос урьдчилан сэргийлэх, гол горхи, булаг шанд, рашааны эхийг тохижуулан хамгаалах, усны нөөцийн нөхөн сэргээх чадварыг сайжруулах арга хэмжээ авах;
- Хамгаалалт барьж тохижуулсан усны эх үүсвэр, булаг шандын эхийн тоог нэмэгдүүлэх;
- Баталгаат ундааны усны хангамжгүй хүн амын эзлэх хувийг 50 хувьд, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг 90 хувьд хүргэж тус тус бууруулах.

Стратегийн зорилт 4. Ойн нөөцийг тогтвортой ашиглаж, ой хамгаалах, нөхөн сэргээх, экологийн тэнцвэрийг хадгалах нөхцөлийг хангана.

- Ойн нөөцийг хамгаалах, ойжуулах, ойн аж ахуйн арга хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр 200 га –аас доошгүй талбайд ойжуулалтын ажил хийх;

- Аймгийн ойн нөөцийг сум, багийн нутаг дэвсгэрийн хэмжээнд шинэчлэн тогтоож, экологи-эдийн засгийн үнэлгээ хийлгэх, нөхөн сэргээх, ашиглах, хамгаалах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх;
- Орон нутгийн экосистемийн тэнцвэрт байдлыг хангахад онцгой ач холбогдолтой бүхий газруудыг улс, аймаг орон нутгийн хамгаалалтад авах;
- Ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх ажлыг мэргэжлийн боловсон хүчин, тоног төхөөрөмжөөр хангах;
- Жил бүр нийтээр мод тарих өдрөөр хот суурин газрыг цэцэрлэгжүүлэх, гол усны эх, тариалангийн талбай, автозамын дагуу ойн зурвас байгуулах арга хэмжээ авах;
- Ойн нөхөн сэргээлтийн ажлыг эдийн засгийн хөшүүрэг хэрэглэн урамшуулж, энэ талын сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулах;
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг судалгаатай хэрэгжүүлэх.

Стратегийн зорилт 5. Амьтан, ургамлын аймгийн нөөцийн хомсдолыг хязгаарлаж, тэдгээрийг байгалийн жамаар нөхөн сэргэх, тогтвортой ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

- Экологи-эдийн засгийн үнэлгээ хийх үндсэн дээр аймгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах хөтөлбөр хэрэгжүүлэх;
- Байгаль орчны доройтол, ургамал амьтны хорогдолтой тэмцэх, нөхөн үржүүлэх, нутагшуулах ажлыг явуулахад үндэсний уламжлалт аргуудыг дэлхийн дэвшилтэт арга, технологитой хослуулан хэрэглэх;
- Байгалийн унаган төрх, шим мандлын тэнцвэрт байдлыг хадгалах, биологийн төрөл зүйлийг хайрлан хамгаалах үзэл бодлыг хүүхэд, залуучуудад төлөвшүүлэх;
- Нэн ховор, устах аюул нүүрлэж буй амьтан, ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;
- Биологийн төрөл зүйлийг хамгаалах, байгалийн аясаар нөхөн сэргэх боломж нөхцөлийг бүрдүүлж, төсөвт тодорхой хөрөнгө тусган хэрэгжүүлэх;
- Тусгай хамгаалалттай газар нутгийн экосистемийн хөгжлийн горим, зүй тогтлыг танин мэдэх, байгалийн нөөц, баялгийг үнэлж тодорхойлох, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх чиглэлийн судалгааг өргөжүүлж, мэдээллийн сан бүрдүүлэх;
- Дархан цаазат газар ба байгалийн цогцолбор газрын орчны бүсүүдэд байгаль орчинд халгүй аж төрөх хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэх;

- Ховор, нэн ховор амьтан ургамлыг сэргээн нутагшуулах, тарималжуулах, зориудын аргаар үржүүлэх, генийн санг хамгаалах тогтолцоо бүрдүүлж, гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрт хамруулах;
- Агнуурын эдэлбэр нутагт ан амьтдад зориулан өвс тэжээл бэлдэх, булаг шанд задгайлах, тэжээлийн ургамал тариалах, үүр ноохой бэлдэх, долооц тавих, мараа ургуулах зэрэг биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэн, эдэлбэр нутгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах, аж ахуй зохион байгуулалтын арга хэмжээнүүд хэрэгжүүлэх.

Стратегийн зорилт 6. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, цөлжилтийг сааруулах чадавхийг бүрдүүлнэ.

- Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны төлөв байдал, байгалийн гамшгийн мэдээллийн төв байгуулах;
- Аюулт үзэгдлийг урьдчилан тооцоолох, олон нийтэд мэдээлэх чиглэлээр аймаг, сумын түвшинд цаг уурын албадын чадавхийг дээшлүүлэх;
- Мэргэжлийн хяналтын лабораторуудыг орчин үеийн техник хэрэгслэлээр бэхжүүлж, мэргэжилтнүүдэд оношлогоо шинжилгээний орчин үеийн мэдлэг эзэмшүүлэх;
- Байгаль, цаг уурын гамшгийн аюулыг бууруулах, болзошгүй гамшиг ослын аюулаас урьдчилан сэргийлэх нөөц бололцоо, техникийн хүчин чадлыг бий болгох;
- Улсын чанартай зам дагуу төвлөрсөн сумуудын орчим мал ихээр бөөгнөрч бэлчээр талхлагдахаас урьдчилан сэргийлэх газар зохион байгуулалт, ашиглалтын оновчтой бодлого явуулах;
- Сул хөрсийг тогтоох, ургамалжуулах талаар гадаад орнуудын дэвшилтэт технологийг судалж нэвтрүүлэх;
- “Ногоон хэрэм” хөтөлбөртэй уялдуулан тал, хээрийн бүсийн ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлэн, ойн зурвас байгуулах;
- Орон нутгийн түлшний хэрэгцээг хангах зорилгоор, халаалтын зуух суурилуулах, сэргээгдэх эрчим хүч, хий ашиглахад хөнгөлөлт үзүүлэх, түлээ мод орлох үр ашигтай хэлбэрүүдийг сонгон нэвтрүүлэх.

ЗУРГАА. ХҮРЭХ ГОЛ ҮР ДҮН, ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ МЕХАНИЗМ

6.1. Цогц бодлогыг хэрэгжүүлснээр хүрэх гол үр дүн

Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлснээр дараахь томоохон үр дүнд хүрнэ:

I үе шат (2010-2015 он)-ны эцэст бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж, эдийн засгийн өндөр өсөлтийг хангах тааламжтай нөхцөл бүрдэхийн зэрэгцээ экспортын үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж, эдийн засгийн бүтцэд аж үйлдвэрийн эзлэх байр суурь сайжирч, эрдэс баялгийн үйлдвэрүүд байгуулагдана.

Өмнөх онуудад хүрсэн түвшингээ хадгалвал ДНБ-ний хэмжээ жилд дунджаар 13.1 хувиар өсч 2015 онд оны 2005 оны үнээр тооцвол 182673.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэнэ. Харин 2015 оны байдлаар ДНБ-ий жилийн өсөлт 9.4 хувьтай байна. Нэг хүнд ногдох ДНБ-ний бодит хэмжээ 2009 онд 1644.9 мянган төгрөг байсан бол 2015 онд 2548.2 мянган төгрөг болж 1.5 дахин өснө.

Нэгдүгээр үе шатанд боловсруулах салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 2.8 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 48.3 хувийг үйлдвэрлэн экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийн эхлэл тавигдана. Уул уурхайн салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 11.1 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарт эзлэх хувийн жин 1.9 хувьд хүрнэ. Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 9.7 хувиар өсч, салбарын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувь 2015 онд 7.4-д хүрнэ. Барилгын салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 12.9 хувиар өсч, барилгын салбарын үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувийн жин 1.3 хувьд хүрнэ.

Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлснээр малын үүлдэрлэг чанар сайжирч, ХАА-н салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 6.1 хувиар өсч, ХАА-н үйлдвэрлэлийн аймгийн ДНБ-д эзлэх хувь 65.1 болно.

Үйлчилгээний салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 23.4 хувиар өсч, энэхүү салбарын ДНБ-д эзлэх хувь 28.8 болно.

Мөн аймгийн хэмжээнд ядуурал, ажилгүйдлийг бууруулж, ЕБС-ийг 12 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжиж, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл болон нялхсын эндэгдлийн түвшин буурна.

II үе шат (2016-2021 он)-ны эцэст эдийн засгийн бүтэц ихээхэн сайжирч, дэвшилтэт техник, технологи, менежмент бүхий үйлдвэрлэл, үйлчилгээ өсөн мэдлэгт суурилсан эдийн засгийн үндэс суурь тавигдах ба өмнөх шатанд байгуулагдсан уул уурхайн болон боловсруулах салбарын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа жигдрэнэ. Эдийн засаг энэ үе шатанд жилд дунджаар 9.4 хувиар өснө. Аймгийн ДНБ-ний 4.7 хувийг аж үйлдвэр барилгын салбарт, 47.3 хувийг орчин үеийн үйлчилгээний салбар үйлдвэрлэнэ.

Энэхүү цогц бодлогыг хэрэгжүүлснээр Хэнтий аймаг хоцрогдлыг харьцангуй богино хугацаанд даван туулж, аймгийн хүн ам төрж өссөн нутагтаа ая тухтай ажиллаж, амьдрах таатай орчин бүрдэх болно.

Хэнтий аймаг 2021 онд жилд 341844.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэх ба нэг хүнд ногдох үйлдвэрлэлийн хэмжээ 2021 онд 3829.1 мянган төгрөгт хүрч 2009 онтой харьцуулбал 2.3 дахин нэмэгдэнэ.

Энэ үе шатанд боловсруулах салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 1.1 хувиар өсч, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий 53.7 хувийг үйлдвэрлэдэг болж аж үйлдвэрлэл давамгайлсан аймаг болох үндэс суурь тавигдана. Олборлох салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 2.7 хувиар өснө. Эрчим хүчний салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 5 хувиар өснө. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин 2021 онд 8.9 хувьд хүрнэ. Барилгын салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 6.6 хувиар өсч, тус салбарын аймгийн ДНБ-д эзлэх хувь 2021 онд 1.1 хувьд хүрсэн байна.

ХАА-н салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 3.8 хувиар өсч, аймгийн ДНБ-д эзлэх хувь 47.9 болно.

Үйлчилгээний салбарын үйлдвэрлэл жилд дунджаар 20.5 хувиар өсч, үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх хувь 47.4 болно. Үйлчилгээний салбарт аялал жуулчлалын салбарын эзлэх хувь 9.7 болно.

Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2021 онд 3829.1 мянган төгрөгт хүрч, 2009 онтой харьцуулбал 2.5 дахин нэмэгдэнэ.

6.2. Цогц бодлогын хэрэгжилтийг хангах механизм

Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлогыг аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрүүд болон энэ баримт бичгийн хүрээнд боловруулах дэд хөтөлбөр, мастер төлөвлөгөө, төслүүдэд тусган хэрэгжүүлнэ.

Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлогын жил бүрийн хэрэгжилтийг Аймгийн Засаг дарга дараа жилийн эхний улиралд багтаан Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнана.

Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлогод тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад тухай бүр хяналт, шинжилгээ хийж, ахиц дэвшил, үйл ажиллагааны үр дагаварыг үнэлэн дүгнэх ажлыг дараахь байдлаар зохион байгуулна:

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлэн дүгнэх үе шатууд:

I үе шат: Бодлогын зорилтын эхний шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдөр);

II үе шат: Бодлогын зорилтын дунд шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдөр);

III үе шат: Бодлогын зорилтын эцсийн шатны үнэлгээ хийх (Хугацаа: 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдөр).

Хяналт, шинжилгээ, үнэлгээг аймгийн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн болон судалгааны, түүнчлэн төрийн бус байгууллагуудын оролцоотойгоор нэгдсэн төлөвлөгөөний үндсэн дээр хийх бөгөөд зохих зардлыг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлнэ. Хяналт, шинжилгээ тасралтгүй явагдана.

Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт бүрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт байх бөгөөд гол анхаарал хандуулах зарим зорилтын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг салбар тус бүрээр урьдчилан тодорхойлсон байна.


_____о О о_____

Хавсралт

Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)-ын тооцооны үндэслэл

Хэнтий аймгийн хөгжлийн ерөнхий чиг хандлагын шинжилгээ хийхдээ юуны өмнө тус аймгийн нэрлэсэн болон бодит ДНБ-ий өөрчлөлтийн чиг хандлагыг Ходрик-Прескотын шинжүүрээр авч үзэв. Ерөнхий чиг хандлагыг дараах зургаас үзнэ үү.

Хэнтий аймгийн Нэрлэсэн ДНБ-ий чиг ханлага



Хэнтий аймгийн бодит, нэрлэсэн ДНБ, сая төгрөг


Он	ДНБ, оны үнээр, сая төгрөг	ДНБ, 2005 оны үнээр, сая төгрөг	Нэрлэсэн ДНБ-ий өсөлт, хувиар	Бодит ДНБ-ий өсөлт, хувиар	Нэрлэсэн ДНБ-ий өсөлт, хувиар	CPI
2000	25659.8	35850.3				10279.4
2001	24626.6	31865.4	0.7	-6.7	-4.02653	11099.2
2002	24800	31543.2	-3.4	-5	0.704117	11291.5
2003	26700	32436.3	7.7	2.8	7.66129	11821.9
2004	34319.5	37566.6	28.5	15.8	28.53745	13120.4

2005	42863.9	42863.9	25.1	14.3	24.89675	14361.7
2006	49867.7	46973.7	16.1	9.4	16.33941	15246.5
2007	62165.3	49723.0	33.5	13.4	24.66065	17955.5
2008	80235.5	52568.3	35.9	-18.5	29.06788	21920.5

Эх сурвалж: Статистикийн эмхэтгэлээс түүвэрлэн авч тооцож гаргалаа.

Хүснэгтээс үзвэл 2007 онтой харьцуулбал 2008 онд нэрлэсэн ДНБ-ий хэмжээ 35.9%-иар өссөн байхад бодит ДНБ-ий хэмжээ 18.5%-иар буурсан байна.

Хэнтий аймгийн бодит ДНБ-ий чиг хандлага



2005 оны үнээр тооцсон үйлдвэрлэлийн хэмжээ, салбаруудаар

Он	2005 оны үнээр						
	ХАА	Уул уурхай, олборлох үйлдвэр	Боловсруулах үйлдвэр	Цахилгаан, дулааны үйлдвэрлэл	Барилга	Үйлчилгээ	Аймгийн ДНБ-ий хэмжээ
2004	8371.9	392.2	102.3	223.3	187.5	5476.4	4571.7
2005	24909.3	335.2	42.2	224.3	171.3	5443.5	4292.5
2006	43489.0	591.4	247.3	82.3	217.5	8042.2	4742.5

2007	37560.8	263.5	48.4	274.4	469.7	8633.0	597
2008	43385.5	304.1	95.0	186.6	404.2	8229.4	802

ДНБ-ий хэмжээ, 2005 оны үнээр, сая төгрөг, 2009-2015 он

он	ХАА	Уул уурхай, олборлох үйлдвэр	Боловсруулах үйлдвэр	Цахилгаан, дулааны үйлдвэрлэл	Барилга	Үйлчилгээ	Аймгийн ДНБ
2009	89396.6	612.7	195.8	370.2	833.0	16077.6	107485.8
2010	95654.4	484.7	244.7	455.4	1041.2	19614.6	117495.0
2011	101393.6	528.4	296.1	500.9	1280.7	23733.7	127733.4
2012	107477.2	533.7	319.8	561.0	1485.6	32515.2	142892.4
2013	112851.1	544.3	345.3	592.5	1723.3	38953.2	155009.7
2014	118493.7	560.7	369.5	669.5	1964.5	45575.2	167633.0
2015	123233.4	583.1	391.7	682.9	2180.6	55601.8	182673.4

Өмнөх онуудад хүрсэн түвшингээ хадгалах замаар тус аймаг үйл ажиллагаагаа явуулж чадвал аймгийн ДНБ-ий хэмжээ жилд дундажаар 13.1 хувийн өсөлттэй байх ба 2015 онд 2005 оны үнээр тооцвол 182673.4 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэх боломжтой болохоор байна. Харин 2015 оны байдлаар ДНБ-ий жилийн өсөлт 9.4% байхаар байна. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 2009 онд 1644.9 мянган төгрөг (бодит хэмжээгээрээ) байсан бол 2015 онд 2548.2 мянган төгрөг болж 1.5 дахин өсөх болно. Тус аймгийн нэг хүнд 2009 онд 1370.7 долларын бүтээгдэхүүн, үйлчилгээ ногдож байсан бол 2015 онд 2123.5 долларын бүтээгдэхүүн, үйлчилгээ ногдож байна. Тодруулбал, нэг хүнд ногдох үйлдвэрлэлийн хэмжээ 2009 онтой харьцуулбал 2015 онд 1.5 дахин нэмэгдэнэ.

2009-2015 он хүртэлх аймгийн салбарын үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн талаархи нарийвчилсан тооцооллыг дараах хүснэгтүүдээр харуулав. ХАА-н үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн тооцоолол

ХАА-н салбарын нэмэгдсэн өртөг, сая төгрөг																	
Он	Үр тариа				Төмс				Хүнсний ногоо				Тэжээл				
	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	
2009	тн	110000	8000	880.0	тн	250000	4000	1000.0	тн	200000	3200	640	тн	600000	264	158.4	2678.4
2010	тн	110000	12000	1320.0	тн	250000	4500	1125.0	тн	200000	3600	720	тн	600000	3600	2160	5325.0
2011	тн	110000	16000	1760.0	тн	250000	5000	1250.0	тн	200000	4000	800	тн	600000	528	316.8	4126.8
2012	тн	110000	20000	2200.0	тн	250000	5500	1375.0	тн	200000	4400	880	тн	600000	6000	3600	8055.0
2013	тн	110000	24000	2640.0	тн	250000	9000	2250.0	тн	200000	6000	1200	тн	600000	792	475.2	6565.2
2014	тн	110000	28000	3080.0	тн	250000	9700	2425.0	тн	200000	6500	1300	тн	600000	8400	5040	11845.0
2015	тн	110000	28000	3080.0	тн	250000	10500	2625.0	тн	200000	7000	1400	тн	600000	924	554.4	7659.4

ХАА-н салбарын нийт нэмэгдсэн өртөг, сая төгрөг

Боловсруулах салбарын үйлдвэрийн нэмэгдсэн өртгийн тооцоолол, 2009-2015 он

Он	Сүү, сүүн бүтээгдэхүүн				Ноолуур				Малын мах				Боловсруулах салбарын үйлдвэрлэлийн хэмжээ, сая төгрөг
	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	
2009	л	500	100000	50	тн	30000	75	2.25	тн	2200000	2250	4,950.0	5002.3
2010	л	500	115000	57.5	тн	30000	75	2.25	тн	2200000	2300	5,060.0	5119.8
2011	л	500	200000	100	тн	30000	85	2.55	тн	2200000	2350	5,170.0	5272.6
2012	л	500	210000	105	тн	30000	90	2.7	тн	2200000	2400	5,280.0	5387.7
2013	л	500	200000	100	тн	30000	92.5	2.775	тн	2200000	2450	5,390.0	5492.8
2014	л	500	210000	105	тн	30000	95	2.85	тн	2200000	2500	5,500.0	5607.9
2015	л	500	205000	102.5	тн	30000	105	3.15	тн	2200000	2550	5,610.0	5715.7

Эрчим хүч, цахилгааны салбарын үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн тооцоолол, 2009-2015 он

Он	Цахилгаан			
	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг
2009	квт, цаг	44.758	2100000	94.0
2010	квт, цаг	44.758	2200000	98.5
2011	квт, цаг	44.758	2300000	102.9
2012	квт, цаг	44.758	2400000	107.4
2013	квт, цаг	44.758	2500000	111.9
2014	квт, цаг	44.758	2600000	116.4
2015	квт, цаг	44.758	2650000	118.6

Олборлох салбарын нэмүү өртөг

Олборлох үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртөг, сая төгрөгөөр													Олборлох үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн дүн, сая төгрөгөөр
Он	Нүүрс				Жонш олборлолт				Алт олборлолт				
	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	
2009	тн	11054.7	10000	110.5	тн	125307.3	10000	1253.1	кг	18790322.6	5	94.0	1457.6
2010	тн	11054.7	12000	110.5	тн	125307.3	12000	1503.7	кг	18790322.6	6	112.7	1727.0
2011	тн	11054.7	12500	110.5	тн	125307.3	15000	1879.6	кг	18790322.6	6	112.7	2102.9
2012	тн	11054.7	12580	110.5	тн	125307.3	16000	2004.9	кг	18790322.6	5	94.0	2209.4
2013	тн	11054.7	13000	110.5	тн	125307.3	20000	2506.1	кг	18790322.6	6	112.7	2729.4
2014	тн	11054.7	13100	110.5	тн	125307.3	23000	2882.1	кг	18790322.6	7	131.5	3124.1
2015	тн	11054.7	13550	110.5	тн	125307.3	24000	3007.4	кг	18790322.6	8	150.3	3268.2

Барилга					Нэмэгдсэн өртөг, сая төгрөг
Он	Тоосго				
	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	
2009	ширхэг	220	2100000	220	462
2010	ширхэг	220	2150000	220	473
2011	ширхэг	220	2120000	220	466.4
2012	ширхэг	220	2160000	220	475.2
2013	ширхэг	220	2200000	220	484
2014	ширхэг	220	2210000	220	486.2
2015	ширхэг	220	2250000	220	495

Аялал жуулчлалын салбарын нэмэгдсэн өртгийн хэмжээ

Он	Аялал жуулчлалын салбараас олох орлого, тэрбум төгрөг	Аялагчдын тоо	Нэг хүнээс олох орлого, төгрөг	ДНБ-д эзлэх хэмжээ, хувиар
2009	126.92	2139	59340.1	0.19
2010	185.81	2609	71208.1	0.25
2011	222.99	2610	85449.8	0.28
2012	331.80	3236	102539.7	0.39
2013	497.71	4045	123047.7	0.55
2014	752.53	5096	147657.2	0.78
2015	1137.83	6422	177188.7	1.12

2009-2015 онуудын нэмэгдсэн өртгийг нэгтгэсэн хүснэгт

Он	Нэмэгдсэн өртгийн дүн, сая төгрөг	Олборлох	Боловсруулах	Эрчим хүч	Барилга	Үйлчилгээ	ХАА
2009	9821.1	1457.6	5002.3	94.0	462	126.92	2678.4
2010	12929.0	1727.0	5119.8	98.5	473	185.81	5325.0
2011	12294.6	2102.9	5272.6	102.9	466.4	222.99	4126.8
2012	16566.5	2209.4	5387.7	107.4	475.2	331.80	8055.0
2013	15881.0	2729.4	5492.8	111.9	484	497.71	6565.2
2014	21932.1	3124.1	5607.9	116.4	486.2	752.53	11845.0
2015	18394.7	3268.2	5715.7	118.6	495	1137.83	7659.4

2009-2015 онуудын нийт үйлдвэрлэлийн хэмжээ, нэг хүнд оногдох ДНБ-ий хэмжээ

2009-2015 он хүртэлх ДНБ-ий хэмжээ, сая төгрөг Нэмэгдсэн өртөг+Экстраполяцийн арга								Нэг хүнд оногдох ДНБ, мянган төгрөг	Хүн ам	Долларын ханш	Нэг хүнд оногдох ДНБ, а доллар
Он	ДНБ, мянган төгрөг	Олборлох	Боловсруулах	Эрчим хүч	Барилга	Үйлчилгээ	ХАА				
2009	117306.9	2070.2	5198.0	464.2	1294.95	16204.48	92075.0	1644.9	71316.0	1200.0	1370.7
2010	130424.0	2211.7	5364.4	553.9	1514.1875	19800.44	100979.4	1798.2	72529.0	1200.0	1498.5
2011	140027.9	2631.3	5568.6	603.9	1747.0606	23956.69	105520.4	1898.4	73762.0	1200.0	1582.0
2012	159459.0	2743.1	5707.5	668.5	1960.7663	32846.98	115532.2	2125.7	75016.0	1200.0	1771.4
2013	170890.7	3273.8	5838.1	704.4	2207.2569	39450.89	119416.3	2240.0	76291.0	1200.0	1866.7
2014	189565.1	3684.8	5977.4	785.9	2450.7129	46327.75	130338.7	2443.2	77588.0	1200.0	2036.0
2015	201068.1	3851.3	6107.3	801.5	2675.6093	56739.60	130892.8	2548.2	78907.0	1200.0	2123.5

Дээрх тооцооллоос үзэхэд 2015 оны байдлаар тус аймаг жилд 201068.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэх ба нэг хүнд оногдох үйлдвэрлэлийн хэмжээ 2015 онд 2548.2 мянган төгрөгт хүрч 2009 онтой харьцуулбал 903.3 мянган төгрөгөөр нэмэгдэх болно. Ам доллараар илэрхийлэгдсэн нэг хүнд оногдох ДНБ-ий хэмжээ 2009 онтой харьцуулбал 2015 онд 1.5 дахин нэмэгдэнэ.

2016-2021 он хүртэлх аймгийн салбарын үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн талаархи нарийвчилсан тооцооллыг дараах хүснэгтүүдээр харуулав. ХАА-н үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн тооцоолол

Он	Үр тариа				Төмс				Хүнсний ногоо				Тэжээл				Нийт нэмэгдсэн өртөг, сая төгрөг
	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	
2016	тн	110000	28000	3080	тн	250000	11200	2800	тн	200000	7500	1500	тн	600000	8400	5040	12420.0
2017	тн	110000	28000	3080	тн	250000	12000	3000	тн	200000	7600	1520	тн	600000	8400	5040	12640.0
2018	тн	110000	30000	3300	тн	250000	12400	3100	тн	200000	7700	1540	тн	600000	9000	5400	13340.0
2019	тн	110000	30500	3355	тн	250000	12500	3125	тн	200000	7750	1550	тн	600000	9150	5490	13520.0
2020	тн	110000	31000	3410	тн	250000	12600	3150	тн	200000	7800	1560	тн	600000	9300	5580	13700.0
2021	тн	110000	32000	3520	тн	250000	12800	3200	тн	200000	7800	1560	тн	600000	9600	5760	14040.0

Боловсруулах салбарын үйлдвэрийн нэмэгдсэн өртгийн тооцоолол, 2016-2021 он

Он	Сүү, сүүн бүтээгдэхүүн				Ноолуур				Малын мах				Боловсруулах салбарын үйлдвэрлэлийн хэмжээ, сая төгрөг
	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	
2016	л	500	205100	102.55	тн	30000	110	3.3	тн	2200001	2560	5,632.0	5737.9
2017	л	500	205200	102.6	тн	30000	112	3.36	тн	2200002	2550	5,610.0	5716.0
2018	л	500	205150	102.575	тн	30000	115	3.45	тн	2200003	2580	5,676.0	5782.0
2019	л	500	205050	102.525	тн	30000	117	3.51	тн	2200004	2600	5,720.0	5826.0
2020	л	500	204550	102.275	тн	30000	118	3.54	тн	2200005	2620	5,764.0	5869.8
2021	л	500	204580	102.29	тн	30000	119	3.57	тн	2200006	2650	5,830.0	5935.9

Эрчим хүч, цахилгааны салбарын үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн тооцоолол, 2016-2021 он

Он	Цахилгаан			Бодит үйлдвэрлэл, сая төгрөг
	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	
2016	квт, цаг	44.758	2700000	120.8
2017	квт, цаг	44.758	2800000	125.3
2018	квт, цаг	44.758	2900000	129.8
2019	квт, цаг	44.758	3100000	138.7
2020	квт, цаг	44.758	3350000	149.9
2021	квт, цаг	44.758	3925000	175.7

Олборлох салбарын нэмүү өртөг

Олборлох үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртөг, сая төгрөгөөр													
Он	Нүүрс				Жонш олборлолт				Алт олборлолт				Олборлох үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн дүн, сая төгрөгөөр
	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	
2016	тн	11054.7	18000	199.0	тн	125307.3	24500	3070.0	кг	18790322.6	9	169.1	3438.1
2017	тн	11054.7	19500	215.6	тн	125307.3	24600	3082.6	кг	18790322.6	10	187.9	3486.0
2018	тн	11054.7	20500	226.6	тн	125307.3	24800	3107.6	кг	18790322.6	13	244.3	3578.5
2019	тн	11054.7	21500	237.7	тн	125307.3	24900	3120.2	кг	18790322.6	15	281.9	3639.7
2020	тн	11054.7	23500	259.8	тн	125307.3	25000	3132.7	кг	18790322.6	16	300.6	3693.1
2021	тн	11054.7	25500	281.9	тн	125307.3	25000	3132.7	кг	18790322.6	18	338.2	3752.8

Барилга					Нийт нэмэгдсэн өртөг, сая төгрөг
Он	Тоосго				
	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ, төгрөг	Үйлдвэрлэл, биет хэмжээгээр	Бодит үйлдвэрлэл, сая төгрөг	
2016	ширхэг	220	2253000	495.66	495.7
2017	ширхэг	220	2255000	496.1	496.1
2018	ширхэг	220	2257000	496.54	496.5
2019	ширхэг	220	2259000	496.98	497.0
2020	ширхэг	220	2261000	497.42	497.4
2021	ширхэг	220	2263000	497.86	497.9

Аялал жуулчлалын салбарын нэмэгдсэн өртөг

Он	Аялал жуулчлалын салбараас олох орлого, тэрбум төгрөг	Аялагчдын тоо	Нэг хүнээс олох орлого, төгрөг	ДНБ-д эзлэх хэмжээ, хувиар
2016	1734.05	8155	212626.4	1.62
2017	2663.50	10439	255151.7	2.36
2018	4123.09	13466	306182.0	3.48
2019	6432.03	17506	367418.4	5.19
2020	10033.96	22758	440902.1	7.75
2021	15652.98	29585	529082.5	11.58

2016-2021 онуудын салбаруудын нэмэгдсэн өртгийн нэгтгэл

2016-2021 он хүртэлх аймгийн салбаруудын үйлдвэрлэл							
Он	ДНБ, мянган төгрөг	Олборлох	Боловсруулах	Эрчим хүч	Барилга	Үйлчилгээ	ХАА
2016	23946.5	3438.1	5737.9	120.8	495.7	1734.05	12420.0
2017	25126.9	3486.0	5716.0	125.3	496.1	2663.50	12640.0
2018	27450.0	3578.5	5782.0	129.8	496.5	4123.09	13340.0
2019	30053.5	3639.7	5826.0	138.7	497.0	6432.03	13520.0
2020	33944.3	3693.1	5869.8	149.9	497.4	10033.96	13700.0
2021	40055.2	3752.8	5935.9	175.7	497.9	15652.98	14040.0

2016-2021 онуудын нийт үйлдвэрлэлийн хэмжээ, нэг хүнд оногдох ДНБ-ий хэмжээ

2016-2021 он хүртэлх ДНБ-ий хэмжээ, сая төгрөг Нэмэгдсэн өртөг+Экстраполяцийн арга								Нэг хүнд оногдох ДНБ, мянган төгрөг	Хүн ам	Долларын ханш	Нэг хүнд оногдох ДНБ, ам доллар
Он	ДНБ, мянган төгрөг	Олборлох	Боловсруулах	Эрчим хүч	Барилга	Үйлчилгээ	ХАА				
2016	214203.4	4050.4	6149.1	831.0	2872.5	60949.94	139350.4	2648.4	80879.0	1100.0	2407.7
2017	257369.9	4135.0	6149.4	892.3	3079.8	100369.71	142743.7	3104.5	82901.0	1100.0	2822.3
2018	277252.4	4266.4	6232.8	919.8	3302.4	116485.24	146045.7	3262.8	84974.0	1100.0	2966.2
2019	291794.5	4362.0	6287.2	960.4	3460.0	128906.77	147818.2	3350.2	87098.0	1100.0	3045.6
2020	307250.6	4437.1	6377.1	1008.5	3626.3	140714.51	151087.1	3441.6	89276.0	1100.0	3128.7
2021	341844.0	4526.5	6504.1	1072.9	3933.4	162015.20	163791.9	3829.1	89276.0	1100.0	3481.0

Тооцооллын үр дүнгээс үзэхэд 2021 оны байдлаар тус аймаг жилд 341844.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үйлдвэрлэх ба нэг хүнд оногдох үйлдвэрлэлийн хэмжээ 2021 онд 3829.1 мянган төгрөгт хүрч 2009 онтой харьцуулбал 2.3 дахин нэмэгдэх болно. Ам доллараар тооцсон нэг хүнд оногдох ДНБ-ий хэмжээ 2009 онтой харьцуулбал 2021 онд 2.5 дахин нэмэгдэнэ.

Боловсруулах салбарын үйлдвэрлэлийн талаар

Нэгдүгээр үе шат: (2009-2015 он): Боловсруулах салбарын үйлдвэрлэлийг эдгээр үеүдэд жилд дундажаар **2.8** хувиар өсгөж, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий **48.3** хувийг үйлдвэрлэж экспортын баримжаатай үйлдвэрлэлийн үндэс суурийн эхлэлийг бий болгож чадна.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): Боловсруулах салбарын үйлдвэрлэлийг эдгээр үеүдэд жилд дундажаар **1.1** хувиар өсгөж, аж үйлдвэрийн салбарын ДНБ-ий **53.7** хувийг үйлдвэрлэдэг болж аж үйлдвэрлэлийн үйлдвэрлэлээр давамгайлсан аймаг болох үндэс суурь тавигдана.

Уул уурхай буюу олборлох салбарын үйлдвэрлэлийн талаар

Нэгдүгээр үе шат: (2009-2015 он): Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг эдгээр үеүдэд жилд дундажаар **11.1** хувиар өсгөнө. Аж үйлдвэрийн салбарт эзлэх хувийн жин 1.9%-д хүрнэ.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): Олборлох салбарын үйлдвэрлэлийг эдгээр үеүдэд жилд дундажаар **2.7** хувиар өсгөнө.

Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн талаар

Нэгдүгээр үе шат: (2009-2015 он): Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг эдгээр үеүдэд жилд дундажаар **9.7** хувиар өсгөнө. Уг салбарын аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувийг 2015 онд 7.4%-д хүргэнэ.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): Эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийг эдгээр үеүдэд жилд дундажаар **5** хувиар өсгөнө. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд эрчим хүчний салбарын үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 2021 онд **8.9%**-д хүргэнэ.

Барилгын салбарын үйлдвэрлэлийн талаар

Нэгдүгээр үе шат: (2009-2015 он): Барилгын салбарын үйлдвэрлэлийг эдгээр үеүдэд жилд дундажаар **12.9** хувиар өсгөнө. Барилгын салбарын үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувийн жин 2009 онд **1.1%** байсан бол 2015 онд **1.3%**-д хүрнэ.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): Барилгын салбарын үйлдвэрлэлийг эдгээр үеүдэд жилд дундажаар **6.6** хувиар өсгөнө. Уг салбарын аймгийн ДНБ-д эзлэх хувь 2021 онд **1.1%**-д хүрсэн байна.

ХАА-н салбарын үйлдвэрлэлийн талаар

Нэгдүгээр үе шат: (2009-2015 он): ХАА-н салбарын үйлдвэрлэлийг эдгээр үеүдэд жилд дундажаар **6.1** хувиар өсгөнө. ХАА-н салбарын үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь 2009 онд 78.4% байсан бол 2015 онд **65.1%** болж өөрчлөгдөнө.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): ХАА-н салбарын үйлдвэрлэлийг эдгээр үеүдэд жилд дундажаар **3.8** хувиар өсгөнө. 2021 онд ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь **47.9%** болно.

Үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн талаар

Нэгдүгээр үе шат: (2009-2015 он): Үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийг эдгээр үеүдэд жилд дундажаар **23.4** хувиар өсгөнө. Уг салбарын ДНБ-д эзлэх хувийг **28.2%**-д хүргэнэ.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): Үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийг эдгээр үеүдэд жилд дундажаар **20.5** хувиар өсгөнө. Үйлчилгээний салбарын ДНБ-д эзлэх жин 2021 онд 47.4% байна. Үйлчилгээний салбарт аялал жуулчлалын салбарын эзлэх хувийн жин 2021 онд 9.7%-ийг эзлэх болно.

Нэг хүнд ногдох ДНБ

Нэгдүгээр үе шат: (2009-2015 он): Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээ 2009 онд **1644.9** мянган төгрөг байсан бол 2015 онд **2548.2** мянган төгрөгт хүргэж нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээг 2009 онтой харьцуулбал **1.5** дахин нэмэгдүүлэх ба харин хүн амын дундаж өсөлтийг жил бүр **1.5** хувь байхаар тооцсон. Доллараар тооцсон нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээг 2015 онд **2123.5** ам долларт хүргэнэ.

Хоёрдугаар үе шат: (2016-2021 он): Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээг 2021 онд **3829.1** мянган төгрөгт хүргэнэ. Нэг хүнд ноогдох ДНБ-ий хэмжээг 2021 оны эцэст **3481** ам долларт хүргэх ба 2009 онтой харьцуулбал **2.5** дахин нэмэгдсэн байх болно.

**“Хэнтий аймгийн хөгжлийн цогц
бодлого” (2009-2021)-той
холбодолтой бусад материал**

“Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого”-ын төслийн товч танилцуулга

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилж, манай орны эрдэмтэд, улс төрчид, иргэдийн өргөн оролцоотойгоор боловсруулж, УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2007-2021 он)”-д тулгуурлан “Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2009-2021 он)”-ыг боловсруулав.

Аймгийн цогц бодлогын төслийг боловсруулахдаа өнөөдөр зах зээлийн эдийн засагт суурилсан ардчилсан тогтолцоот орнуудад өргөн хэрэглэж байгаа индикатив төлөвлөлтийн аргазүйг хэрэглэсэн болно. Мөн эдийн засаг-математикийн загвараар аймгийн эдийн засгийн өсөлтийн болон эдийн засгийн салбарын бүтцийн хэтийн төлвийг тооцоолон тусгав.

“Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010- 2021он)”-ыг “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)”, “Монгол Улсын Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөр (2015 он хүртэл)” болон Монгол Улсын хөгжлийн бодлогын бусад баримт бичгүүдэд нийцүүлсэн бөгөөд түүнд “аймгийн хэмжээний хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн үзэл санаа, хэрэгжилтийн явц, үр дүн, залгамж чанар тусгалаа олсон болно.

Хэнтий аймгийн урт хугацааны хөгжлийн стратегийн зорилтууд, хүрэх үр дүнг 2010-2015 он, 2016-2021 он гэсэн хоёр үндсэн үе шатаар авч үзэв.

“Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)”-ыг Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газартай Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шинжлэх ухааны Академийн харъяа Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн байгуулсан 2008 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн №ХЭ/ҮХХ-08 тоот гэрээний дагуу төслийн удирдагч, доктор, профессор Д.Бямбаа, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн ахлах судлаач Л.Нямцэрэн, зөвлөх судлаач А.Зоригсайхан, Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн багш, доктор П.Гантөмөр, Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр Б.Сайнбилэг, Б.Цогтбаатар, Р.Онгонцэцэг, Г.Хажидмаа нарын судлаачдын баг боловсруулж, Хэнтий аймгаас Улсын Их Хуралд сонгогдсон УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Н.Ганбямба, Д.Арвин нарын саналыг тусгасан болно.

Энэхүү цогц бодлогыг Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн 2009 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн гарсан санал, зөвлөмжийг тусгасны зэрэгцээ Хэнтий аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахын өмнө тус аймагт үйл ажиллагаа явуулж байгаа агентлагуудын түвшинд хэлэлцүүлэн ирүүлсэн санал, Хэнтий аймгийн ЗДТГ, ИТХ-ын удирдлагаас ирүүлсэн санал, мөн аймгийн ИТХ-ын Байнгын хороодын гишүүд, тухайн салбартай холбоотой хэлтэс, агентлагуудын удирдлага, мэргэжилтнүүдийн оролцсон салбар бүрийн хэлэлцүүлэг, тодруулгуудыг тусгасан болно. Мөн Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын хөгжлийн бодлогын хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийн “Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлогын төлөвлөгөөнд оруулах санал”-ыг тусгав.

**Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шинжлэх ухааны
Академийн харъяа Үндэсний хөгжлийн хүрээлэн**

Төсөл

**МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2009 оны сарын-ны өдөр

Дугаар

Өндөрхаан

**Аймгийн хөгжлийн цогц бодлого
батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 -ийн а, е заалтуудыг үндэслэн аймгийн ИТХ-ын дугаар хуралдаанаас Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлогын төслийн баримт бичгийг хэлэлцээд ТОГТООХ НЬ:

Нэг: “Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого /2010-2021/”-ыг хавсралтаар баталсугай.

Хоёр: Аймгийн хөгжлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг аймгийн жил жилийн төсөв, нийгэм, эдийн засгийн хөгжлийн дунд хугацааны бопон үндсэн чиглэлд тусгах замаар хэрэгжилтийг зохион байгуулж, явц үр дүнг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил тутам танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ч.Эрдэнэбаатар/-д даалгасугай.

ДАРГА Ц.ЛХАГВАСҮРЭН

Эрдэм шинжилгээний ажлын тайланг хүлээлцсэн акт

“Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого” (2010-2021) төслийн ажлын тайланг гүйцэтгэгч Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шинжлэх ухааны Академийн харъяа Үндэсний хөгжлийн хүрээлэнгээс Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгч 2009 оны 12 дугаар сарын ...-ны өдөр энэхүү актыг үйлдэв

Улсын бүртгэлийн дугаар 200600134
Төслийн ажлын тайлан
Нууцлалын ангилал “Б”

Нэг. “Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого” (2010-2021)- 51 хуудас
(2 ширхэг)

Хоёр. Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)-ын тооцооны
Үндэслэл- 13 хуудас (2 ширхэг)

Гурав. Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого” (2010-2021)- CD (1 ш)

Дөрөв. Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн хурлын
2009 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн тогтоол №1- 1 хуудас

Тав. “Хэнтий аймгийн хөгжлийн цогц бодлого” (2009-2021)-той
холбогдолтой бусад материал

Төслийн товч танилцуулга- 2 хуудас
Хэнтий аймгийн ИТХ-ын тогтоолын төсөл- 1 хуудас
Эрдэм шинжилгээний ажлын тайланг хүлээлцсэн акт – 1 хуудас
УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Н.Ганбямба, Д.Арвин
нарын санал - 5 хуудас

Тайлан өмчлөгч::

Үндэсний хөгжлийн
хүрээлэн

Захиалагч байгууллага:

Хэнтий аймгийн Засаг даргын
Тамгын газар ()

Төслийн удирдагч:

Доктор, профессор Д.Бямбаа / ҮХХ /

Хүлээлгэн өгсөн:

Б.Цогтбаатар / ҮХХ /

Хүлээн авсан:

Хэнтий аймгийн Засаг даргын
Тамгын газар ()